

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8-38
<hr/>	
<i>1. Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан/</i>	8-21
<i>2. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	21-22
<i>3. Улсын Их Хурлын Тамгын газрын хууль зүйн дүгнэлт/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нараас 2023.04.05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгтгэсэн төслийн талаар/</i>	22-26
<i>4. “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./</i>	26-29
<i>5. “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./</i>	29-31
<i>6. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	31-38

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 13-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 35 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Мөнхбаатар;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Ц.Сэргэлэн;

Тасалсан: Ш.Раднаасэд.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлэг, “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл, “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслүүдийн хууль санаачлагч байхгүй тул түр хойшлуулав./11:45/

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ц.Мөнх-Оргил, Д.Ганбат нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч Б.Энхбаяр, Монгол Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Энхбаяр танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Б.Энхбаяр: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6

Бүгд: 13
53.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын Тамгын газрын хууль зүйн дүгнэлт /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нараас 2023.04.05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгтгэсэн төслийн талаар/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат нар хариулж, тайлбар хийв.

Б.Энхбаяр: Хууль зүйн дүгнэлтийг дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль зүйн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга П.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил нарын тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

Б.Энхбаяр: “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга П.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн

Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энхбаяр: “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ!

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, мөн яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Хосбаяр, Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга З.Баасаням, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Улсын дээд шүүхийн

Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүүгийн хэлтсийн дарга Б.Өүлэн-Үжин, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нягтлан Х.Хажидмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ш.Батцэнгэл, референт Ц.Отгонбаатар нар байлцав.

Төсвийн төслийн талаар Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Хосбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 00 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 35 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Ирцийг танилцуулъя. Их хурлын гишүүн Энхбаяр ирсэн байна. Адьяа ирсэн байна. Бат-Амгалан ирсэн байна. Дэлгэрсайхан ирсэн байна. Мөнх-Оргил ирсэн байна. Пүрэвдорж ирсэн байна. Сандаг-Очир ирсэн байна. Сүхбаатар ирсэн байна. Цогтбаатар ирсэн байна. Энх-Амгалан ирсэн байна.

Өнөөдөр төсөв ярина. Засгийн газрын сайд, Байнгын хорооны гишүүд хүрэлцэн ирнэ үү. Нямбаатар сайд хүрэлцэн ирээрэй. Бямбацогт сайд хүрэлцэн ирээрэй. Учрал сайд хүрэлцэн ирээрэй. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийнэ.

2 дугаарт Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг

соёрхон батлах асуудал байгаа. Засгийн газар 2023 оны 5 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

3-д Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2023 оны 5 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах тухай асуудал байгаа. Санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

4 дүгээрт Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 2 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

5 дугаарт Байнгын хорооноос ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэнэ.

6 дугаарт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн хууль зүйн дүгнэлт гарах тухай асуудлыг хэлэлцэнэ.

7 дугаарт Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд байгаа. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг Авлигатай тэмцэх газраас Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлсэн. Энэ асуудал дээр бол Засгийн газрын санал,

дүгнэлтийг авах шаардлага байгаа. Засгийн газар авлигатай тэмцэх хүрээнд тодорхой “5 Ш” хөтөлбөр хэрэгжүүлж, бодлого хэрэгжүүлж байгаа. Мөн тодорхой төсөв хөрөнгөтэй холбоотой асуудал дээр бол Засгийн газрын санал, дүгнэлтийг бол заавал авах ийм шаардлага байгаа. Тийм учраас энэ асуудлыг Байнгын хорооны даргын хувьд Засгийн газар руу санал авахаар хүргүүлээд, санал авсны дараа Байнгын хороогоороо хэлэлцье гэсэн ийм саналтай байгаа шүү. Ийм асуудлууд байна. Ингээд хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Пүрэвдорж гишүүн хэлэлцэх асуудал дээр саналаа хэлье.

Б.Пүрэвдорж: Хууль зүйн байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 оны төсвийн тодотголыг хэлэлцэнэ. Тэгэхээр хуучин бол нөгөө бид нарт ерөнхий төсвийн буюу аль эсвэл төсвийн тодотголын ерөнхий бичиг баримтыг өгдөг тэр нь энэ байна. Тэгээд Хууль зүйн байнгын хороо бид нар хэлэлцэхдээ бас дотооддоо яг энэ Хууль зүйн байнгын хороо дотор жишээ нь Ерөнхий прокурор ч юм уу, Ерөнхий шүүгч ч юм уу аль эсвэл Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад юу юу нэмэгдээд байгаа юм. Ямар ямар хөрөнгө нэмэгдэж байгаа юм. Ямар ямар хөрөнгө хасагдаж байгаа юм. Тэрийг тодорхой өгдөг тэр нөгөө баримт нь алга байна. Тийм учраас хэлэлцэж эхлэхтэй зэрэгцүүлээд яг энэ задаргаануудаа өгөөч. Одоо жишээ нь 158 тэрбум төгрөгөөр Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц нэмэгдэж байгаа юм байна. Тэгээд тэр нь аль салбар дээр, цагдаа дээр цалингийн зардал нь нэгж хэдэн төгрөгөөр нэмэгдэж байгаа юм. Аль эсвэл шүүхийн шинжилгээ ч юм уу, аль эсвэл Гадаадын харьяат дээр хэдэн төгрөгөөр цалин нэмэгдэж байгаа юм. Тэрийг нь бид нар мэдэх шаардлагатай байхгүй юу даа. Гол нь тэр нөгөө салбар салбараар байдаг тэр танилцуулга нь энэ

дээр ерөөсөө байхгүй байна. Тийм учраас тэрийг шаардаж байна.

Б.Энхбаяр: Пүрэвдорж гишүүний санал зарчмын хувьд зөв зүйтэй санал байна шүү. Ажлын хэсэг Засгийн газрын холбогдох хүмүүс сая Пүрэвдорж гишүүний хэлж байгаа асуудлуудыг Байнгын хорооны гишүүдэд энэ хугацаанд тараагаарай.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Эхний асуудал Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Батрагчаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Баянбилэг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Гансэлэм Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга, Хосбаяр Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга, Баасанням Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга, Адъяахишиг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комиссын Тамгын газрын дарга, Заяадэлгэр Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга, Хажидмаа Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нягтлан, Өүлэн-Үжин Улсын Бүртгэлийн ерөнхий газрын Санхүүгийн хэлтсийн дарга гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Монгол улсын Засгийн

газрын гишүүн Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Жавхлан сайдыг дуудаарай. Байхгүй бол хойшлууллаа шүү. Оролцож байгаа албан тушаалтнууд байгаа. Сангийн сайд Болдын Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Зулхар, Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, Тэргүүлэх аудитор Самбууням, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал тэргүүлэх аудитор Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Батжаргал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Тунгалагтамир, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Тулга, Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Отгонжаргал, Сангийн яамны төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Төгөлдөр, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Цолмон, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Дашням гэсэн албан тушаалтнууд оролцож байгаа юм байна аа.

Хууль санаачлагч байхгүй учраас энэ асуудлыг хойшлуулъя.

Дараагийн асуудал. Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах

үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Бямбацогт танилцуулна. Бямбацогт сайд байна уу. Алга байна. Энэ асуудлыг хойшлууллаа. Хууль санаачлагчид байхгүй.

3 дахь асуудал. Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье. Энэ асуудлыг төсөл санаачлагчийн танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Бямбацогт танилцуулна. Мөн алга байна хойшлууллаа.

4 дэх асуудалдаа оръё. Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулж боловсруулсан. Энэ хүрээнд танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч би өөрөө хийх юм байна. Би байна. Санаачлагч байгаа юм байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Монгол Улсын Шүүхийн тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг

бүхий ажлын хэсгийг Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 7 дугаар тогтоолоор байгуулсан.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ганбат, Раднаасэд, Сүхбаатар, Цогтбаатар нар орж ажилласан болно.

Түүнчлэн ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй ажлын дэд хэсэгт Улсын дээд шүүх, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн болон холбогдох албаны хүмүүс орж ажиллан холбогдох судалгаа мэдээлэл гаргуулан ажиллалаа.

Ажлын хэсэг 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно. Тухайлбал Улсын Дээд шүүх шүүн таслах ажиллагааны талаар хэрэгжүүлэх бүрэн эрхт эрх зүйн шинэ ойлголт эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байх гэсэн заалтыг нэмж тусгав.

Улсын Дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатын шүүхийн магадлалыг шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хуулийг Улсын Дээд шүүхийн тогтоол тайлбараас өөрөөр хэрэглэсэнд хяналтын журмаар хянан шийдвэрлэж байхаар, Улсын Дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар хэрэгжүүлэх бүрэн эрхэд давж заалдах шатын шүүх хуралдаанд бэлтгэх ажлын бүрдэл, хугацааны хуваарилалт, дарааллыг тогтоох, бэлтгэл хуралдаан хийх журмыг хэлэлцэж батлахаар, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсгийг давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан

үзнэ гэж өөрчлөн найруулж үүнтэй уялдуулан 118.4 дэх хэсгийг хасахаар тусгав.

Монгол Улсын шүүхийн тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хуралдаанд Улсын Дээд шүүхийг төлөөлж Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас Байнгын хорооны хуралдаанд энэ асуудалтай холбоотойгоор асуулт хариултад хариулахаар томилогдсон Улсын Дээд шүүхийн шүүгч Цогт шүүгч хүрэлцэн ирсэн байна. Цогч шүүгчийг 5 номерын микрофонд урьж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн I дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Адьшаа гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн ажлын хэсгийн гишүүн

байгаа. Яах вэ өөрөөсөө асуух уу л гэж. 1 асуудал дээр. Тэрийгээ та тэр үед нь хэлэх юм уу? Үгүй энэ чинь зүйл бүрээр хэлэлцэж байгаа шүү дээ. 1 дүгээр зүйл гэдэг нь Дээд шүүхийн журам гаргах эрхийг л ярих гэж байна. Энэ дээр та яриагүй шүү дээ. 100 хувийн саналаар дэмжигдсэн. Та нөгөө өөрийнхөө асуудал дээр та асуултаа асуучих Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 02 тоот дүгнэлттэй холбогдуулж өнөөдөр Шүүхийн тухай хуулийг өөрчлөх асуудлыг хэлэлцэж байгаа юм байна. Үгүй ээ, Үндсэн хууль зөрчөөгүй гэдэг юм ярьчихаад дээр нь ингээд түдгэлзүүлсэн асуудлыг чинь Их Хурал хэлэлцэж болдог юм уу. Их Хурал өөрөө энэ хууль тогтоох эрх мэдэлдээ будилаан гаргаж байна шүү дээ. Үндсэн хууль зөрчсөн, зөрчөөгүй асуудлыг л бид хэлэлцэж хуульд өөрчлөлт оруулахаас биш, зөрчөөгүй гэгчээд түдгэлзүүлсэн асуудлыг бид Үндсэн хуулийн цэцийн асуудал Улсын Их Хурал дээр сонсгол хэлэлцье л дээ. Энэ Үндсэн хуулийн цэц чинь бүр дэндэж байгаа шүү дээ. Дандаа захиалгаар асуудал хэлэлцдэг. Тэгээд энд ямар асуудал цаана нь яваад байна. Шүүх эрх мэдлийн тухай асуудал. Шүүхийн шийдвэртэй холбоотой асуудал чинь өнөөдөр нийгэмд ямар байдалтай болчихоод байгаа билээ. Тэгээд энийг хэлэлцэж байгаа нь Улсын Их Хурал хууль зөрчиж байна гэж үзэж байна. Хууль зөрчиж байна. Үндсэн хууль зөрчөөгүй гэгчээд Үндсэн хуулийн цэц нь түдгэлзүүлж байдаг. Гэтэл тэр түдгэлзүүлсэн юмыг нь Үндсэн хууль зөрчөөгүй гэдэг асуудлыг Улсын Их Хурал авч хэлэлцээд, хууль оруулж байгаа нь ерөөсөө өөрсдөө хууль зөрчиж байна гэж үзэж байна. Улсын Их Хурал. Дээр нь энэ 25 дугаар зүйлийн 8.10 дугаар заалт давж заалдах шатын шүүх хуралдааны бэлтгэл хуралдаанд бэлтгэл ажлын бүрдэл, хугацааны хуваарилалт, дарааллыг тогтоох, бэлтгэл хуралдааныг хийх журмыг хэлэлцэж

батална гэдэг энэ чинь юу гэж ойлгох вэ. Юу гэж ойлгох юм. Тэрийг шүүхийн захиргааны ажлыг энэ дээр хуулиар ингэж оруулж ирээд цаана нь ямар асуудал нуугдаад байна. Ер нь юу оруулж ирэх гээд өнөөдөр ингээд цэц нь будилаад нэг шийдвэр гаргадаг, тэгээд цаана нь ингээд Хууль зүйн байнгын хороо нь энд нэг ийм юм оруулаад явж байгаа. Анхнаасаа л би энэ шүүхийн тухай хууль хэлэлцэхэд ярьж байсан. Давж заалдах тэр Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхтэй холбоотой. Давж заалдах эрхийг хангах асуудал угаасаа Шүүхийн тухай хууль дээр учир дутагдалтай байна л гэж би удаа дараа байр сууриа илэрхийлж байсан. Гэтэл өнөөдөр ийм юм оруулж ирээд, Улсын Их Хурал Монгол Улсын бүх асуудлыг авч хэлэлцдэг ийм эрхтэй шүү дээ. Дотоод, гадаад төрийн, шүүхийн эцсийн шийдвэрээс бусад бүх юмыг авч хэлэлцдэг юм шүү дээ. Энэ Цэцийнхээ асуудлыг авч хэлэлцье л дээ Улсын Их Хуралд. Яагаад өнөөдөр ингээд нэг ийм юм гаргачхаад тэгээд цаана нь ямар захиалга явагдаад байна. Ийм байр суурьтай байна. Энийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж байна. Эхлээд Цэц өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Шүүх эрх мэдлийн тухай хууль зөрчөөд, Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчөөгүй гэж дүгнэлт гаргачхаад, тэгээд түдгэлзүүлсэн асуудлыг Улсын Их Хурал дээр нээлттэй сонсгол хийе. Нээлттэй сонсгол хийе. Тэрний дараа энэ асуудлыг оруулж ирье. Ингэж бид нар өнөөдөр шүүх эрх мэдлээрээ, хууль тогтоох эрх мэдлээрээ ингэж тоглодог тогтолцоондоо бид эвлэрээд, нэг бол би энд нэг захиалга явагдаж байна гэж үзэж байна. Үгүй болбол энэ асуудлыг цэцийнхээ асуудлыг Улсын Их Хурал дээр төлөөлөл болж явуулсан хүмүүс байгаа.

Б.Энхбаяр: Адьяа гишүүний асуултад хариулъя. Шүүхийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй тухай Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 тоот дүгнэлт гарсан. Энэ дүгнэлтийг Улсын

Их Хурал өнгөрсөн 7 хоногт нэгдсэн чуулганаараа хүлээж авсан. Та энэ асуудлыг бол Улсын Их Хурал цэцийн дүгнэлтийг хүлээж авах эсэх асуудлыг хэлэлцэх үед илэрхийлэх байсан байна. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хүлээж авсантай холбоотойгоор Улсын Их Хурлын хурал чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82.2.5-д хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хуралд хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах гэж заасан байгаа. Ийм учраас чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу хугацаатай Засгийн газар, бусад байгууллагаас бас санал заавал авахыг шаарддаггүй ийм дэгийн хуулийн онцлог зохицуулалттай байгаа. Байнгын хорооны тухайд энэ асуудлыг хүлээн авахтай холбоотойгоор Монгол Улсын дээд шүүхэд албан ёсоор хандаж цэцийн дүгнэлттэй холбоотойгоор санал, дүгнэлт авсан байгаа. Улсын дээд шүүх нийт шүүгчдийнхээ хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд холбогдох санал, дүгнэлтээ ирүүлсэн. Энэ санал, дүгнэлтийн дагуу таны сая хөндөгдөж байгаа холбогдох саналууд Улсын дээд шүүхээс ирсэн. Ажлын хэсэг өчигдөр хуралдаад энэ саналыг 100 хувийн саналаар зөв зүйтэй санал байна гэж хүлээж авсан байгаа. Яг Адьшаа гишүүний тухайлан асууж байгаа Давж заалдах шатын хуралдаанд бэлтгэл ажлын бүрдэл, хугацааны хуваарилалт, дарааллыг тогтоох, бэлтгэл хуралдаан хийх журам гэж юу яриад байна вэ гэсэн ийм бас асуулт асуулаа. Энийг бол Улсын дээд шүүх Цогт шүүгч хариулах уу. 5 номерын микрофон хариулъя. 5 номерын микрофон.

Ц.Цогт: Адьшаа гишүүнээс асуултын холбогдох хэсэгт нь хариулт өгье. Өнгөрсөн Шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр болж, мөрдөж эхэлсэн 2 жилийн хугацааны статистик тоон

мэдээг авч үзэх юм бол Монгол Улсын Дээд шүүх хяналтын шатны журмаар нийтдээ гомдол гарсан хэргийн 15 орчим хувийг хүлээн авч, хянан шийдвэрлэдэг болсон байгаа. Үндсэн хуулийн цэцээс гомдол ялгаж шийдвэрлэдэг журмыг бол үндсэндээ Үндсэн хууль зөрчөөгүй байна гэж үзсэн. Харин явцуу байна. 2 заалт нь явцуу байгаа учраас энийг өргөтгөж шүүхэд хяналтын шатны шүүхэд гомдол гаргах тэр боломжийг өргөтгөх ёстой гэсэн шийдвэр гарсан байгаа. Үүний дагуу нэгэнт цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээж авсан учраас Шүүхийн тухай хуулийн 25.8-д зааснаар Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос Улсын дээд шүүхэд хандаж, энэ заалт, хэсгийг боловсронгуй болгох саналаа ирүүл гэсэн. Үүний дагуу бид санал хүргүүлсэн байгаа. Яг энэ нэгэнтээ давж заалдах шатны шүүхээр нийт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 80 гаруй хувь нь хүчин төгөлдөр болж, дуусгавар болж байгаа учраас нөгөө давж заалдах шатын шүүх хуралдаан, давж заалдах шатын шүүхийн шийдвэрийн чанар, хэргийн оролцогчдын эрхийг хангахтай холбоотой асуудал дээр энэ өөрчлөлт шаардлагатай гэж үзсэн байгаа. Өөрөөр хэлэх юм бол давж заалдах шатын шүүхийн журмыг зохицуулсан юм дээр бол ерөөсөө хурал яаж хийх юм бэ гэдэг ерөнхий зохицуулалт, тэгээд нийт гомдол хүлээж авснаас хойш хэргийг 30 хоногийн дотор шийднэ гэсэнээс өөрөөр бол процессын ямар ч зохицуулалт байхгүй байгаа. Тэгэхээр Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанд давж заалдах журмаар хэргийг 30 хоногийн дотор хэрхэн яаж, ямар шат дараалалтайгаар хэлэлцүүлэхээр бэлтгэх юм. Ямар асуудлуудыг шийдвэрлэвэл энэ хүний Үндсэн хуульд заасан шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхийг бүрэн агуулгынх нь хувьд хангасан ийм давж заалдах шатын шүүх хуралдаан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болох юм бэ гэдгийг энэ журмаар зохицуулж өгөх зорилготой байгаа юм. Тэгэхээр Адьшаа гишүүний хэлдэг нөгөө давж заалдах шатны

шүүхийн чанар, шүүн таслах ажиллагааны чанарыг дээшлүүлэхэд зорьсон ийм заалт байгаа.

Б.Энхбаяр: Адьшаа гишүүн нэмэлт нэг минут асуултаа асууя.

Ш.Адьяа: Дараагийн асуудал хэлэлцүүлгүүдэд орохгүй ээ. Тэгэхдээ энд нэг юм нэмээд бас нэгэнт хууль хэлэлцэж байгаа юм чинь Их Хурлын гишүүний хувьд асуучихъя. Эрүүгийн хууль ийм байдаг юм байж. Тэгтэл энэ Захиргааны хэргийн бүх юмыг чинь нэг бүрчлэн заахгүйгээр хэлэлцэнэ гэсэн ийм нэг заалт энд сая харлаа. Тэгээд ер нь иргэдийн шударга шүүхээр шүүлгэх Үндсэн хуулийн зарчмын хүрээнд тэр давж заалдах эрхийг хангах асуудал зөвхөн энд нэг хуралдааны бэлтгэл, бүрдэл хангах, Дээд шүүхийн тайлбараар хязгаарлагдаж болох юм уу. Ер нь энэ дээр нэг тайлбар авъя. Өргөн утгаар нь авч хэлэлцэж болохгүй юм уу.

Б.Энхбаяр: Адьшаа гишүүний асуултад би хариулчихъя. Давж заалдах шүүхийн тухай хууль дээр бид Улсын Дээд шүүхийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үндэслэл, процессыг нэн дэлгэрэнгүй тодорхойлж бичсэн байгаа. Түүнчлэн анхан шатын шүүх дээр хэргийг хуваарилахаас эхлүүлээд хүний оролцоог хүчин зүйлийг багасгасан. Хэргийг шүүгчид хэн шүүгч дээр очуулах вэ гэдгийг бол хүний оролцоогүйгээр шийддэг буюу цаад утгаараа тухайн хэрэгт урьдчилсан байдлаар нөлөөлөх энэ боломжуудыг бүх талаас нь хааж өгсөн байдаг. Ингээд анхан шатын шүүх бол бүх хэргийг анхнаас нь бүтнээр нь, бүх талаас нь үзэж судалж байгаа. Тэгээд шийдвэрээ гаргаж байгаа. Давж заалдах шатын процесс дээр юу орхигдсон байна вэ гэхээр зарим тохиолдолд Захиргааны хэргийн шүүхийн хууль дээр зөвхөн гомдол гаргагчийн шаардлагын хүрээнд Давж заалдах шатын шүүх хэргийг авч үзэхээр процессын хуультай явж байгаа. Давж заалдах шатын шүүх дээр хэргийг хуваарилах энэ үе шат бол харин

эсрэгээрээ Улсын Дээд шүүх болон анхан шатын шүүхээс бид бол бас арай дутуу харсан ийм зүйлүүд бас байгаа юм байна. Тухайлбал Давж заалдах шатын шүүхийн шүүгч бол хэргийг хэнд хуваарилах вэ гэдгийг Ерөнхий шүүгч өөрөө мэдээд байгаа юм. Гэтэл бид нар Дээд шүүх дээр болон анхан шатын шүүх дээр энийг болиулчихсан. Тийм учраас нөгөө хэргийг хэн шүүгч дээр хуваарилж байгаад, хэнтэй нийлж бүрэлдэхүүнтэй шийдэх вэ гэдэг асуудлыг Ерөнхий шүүгч шийдээд байна гэдэг бас нөгөө хонгил яриад байдаг. Энэ дээр нөгөө дур зорго орох, чиглэл орох ийм бас зүйлд бас нөлөөлөлтэй байна.

2 дугаарт анхан шатын шүүх дээр нөгөө бид нар урьдчилсан хэлэлцүүлэг буюу бүрэн нотлох баримтын хэмжээнд иж бүрдэл хангагдаж байж байж шүүх хурал хийдэг ийм тусгай үе шатыг гаргачихсан байдаг. Гэтэл давж заалдах шатын шүүхэд маань ийм юм байдаггүй. Нөгөө бүрдэл хангагдсан байна уу, үгүй юу гэдгийг сайн нягталж үзэ, бүрэлдэхүүнээ хэнтэй шийдэх гэдэг энэ юм дээр нь өөрөө бас тийм дур зорго үзэмж байгаад байх, тэр утгаараа нөгөө давж заалдах шатын шүүхээр хэргээ шударгаар шийдэх энэ иргэдийн үндсэн эрх хараат бус тэр баталгаатай байх нөхцөлийг хангахын тухайд Дээд шүүхэд бол бас ийм журам ороод зохицуулж байя гэсэн Дээд шүүхийн саналыг бол ажлын хэсэг хүлээж авсан байгаа юм.

Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя. Гишүүд асуулт асууж дууслаа.

Тухайлан гаргасан зарчмын зөрүүтэй санал энэ зүйл дээр 1 дүгээр зүйл дээр алга байна. Тэгэхээр 1 дүгээр зүйл дээр санал хураах уу.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбоотойгоор асуулт байна уу. Алга байна. Мөнх-Оргил гишүүн асуулт байна. Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа нөгөө 25.7.5.а чинь Энхбаяр гишүүн ээ, 25.7.5.а чинь Цэцийн шийдвэрээр түдгэлзчихсэн байгаа шүү дээ тийм ээ, он дуустал. Тэгээд он дуусаад түдгэлзэж эхэлнэ гэж байгаа шүү дээ. Одоо хүчинтэй байгаа. Тэгээд 12 сарын 15-ны өдрөөс эхлээд түдгэлзчихнэ. Тэгэхлээр энэ заалт чинь байхгүй болчихно гэсэн үг биз дээ. 25.7.5.а чинь байхгүй болчихно шүү дээ. Түдгэлзчихэж байгаа юм чинь. Тэгээд энэ чинь байхгүй болчихлоор энэ гол юм чинь байхгүй болчихож байгаа юм биш үү. Хаана сэргээж байгаа юм. Үгүй ээ, 2 дээрээ ийм үг байна шүү дээ. Эрх зүйн шинэ ойлголт эс үгүй бол хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэдэг үг байна шүү дээ. Энэ чинь шүүхийн хууль хэрэглээний зөрөөг арилгах гэдэг дээр ярьж байгаа зөв үү? Тийм. Тэгээд энэ чинь шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах гэдгийгээ та нар илүү Цэцийн дүгнэлтийн дагуу илүү өргөн утгатай болгочихлоо гэж ойлгоод байгаа юм уу. Ажлын хэсэг. Тэгэхлээр илүү өргөн утгатай болчихно гэж ойлгох юм уу. Үгүй ээ үгүй. Дээд шүүхийн саналаар биш ээ. Дээд шүүх чинь санал өгдөг л болохоос биш, хууль тогтоохгүй шүү дээ. Тэгээд яахаараа энэ анхан болон давж заалдах шатын шүүхийн гэдэг үгийг нь хасчихаар энэ заалтын чинь хэрэглээ цэцийн тэр гаргасан дүгнэлттэй нийцээд илүү өргөн утгатай, явцууруулаагүй болж байна гэж ойлгоод байгаа юм бэ. Би тэрийг нь ерөөсөө ойлгохгүй.

Б.Энхбаяр: Мөнх-Оргил гишүүний асуултад Цогт шүүгч нэмж хариулбал хариулаарай. Би эхлээд хариулчихъя. Яг энэ зүйлтэй юм байна шүү дээ. Шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах Дээд шүүхийн асуудал нь яг яагаад шударга шүүхээр шүүлгэх эрхийг зөрчсөн юм бэ гээд цэцийн дүгнэлтийн үндэслэл хэсэгт байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр үндэслэл хэсэгт байхгүй болохоор нөгөө чуулган дээр өнгөрсөн 7 хоногт ярьж байсан. Нөгөө тааж унших болчихоод байгаа юм. Цэцийн дүгнэлтийг. Ингэсэн

юм болов уу, тэгсэн юм болов уу. Юу гэж бодож ингэж энийг зөрчсөн гэж гаргасан юм бол гэж бид нөгөө тааж яриад байгаа байхгүй юу. Шийдвэрт нь байхгүй байгаа. Түрүүн Адьшаа гишүүн хэлж байсан. Чуулган дээр Раднаасэд гишүүн, та ч бас хэлж байсан, би ч бас хэлж байсан. Цэцийн дүгнэлтээ ерөөсөө тааж уншаад байна гээд. Шийдвэрт нь байхгүй байгаад байгаа байхгүй юу. Ямар учраас яагаад энэ заалт Үндсэн хуулийн энэ заалтыг зөрчсөн юм бэ гэдэг юм нь Цэцийнхээ шийдвэрт байхгүй байгаад байгаа юм. Тийм учраас нөгөө таны асуултад би бас яг тааж хариулах гээд байгаа юм. Хууль хэрэглээний зөрүүг арилгах энэ асуудал бол аль ч Улсын Дээд шүүхийн ерөөсөө үндсэн чиг үүрэг нь байгаад байгаа юм. Ийм чиг үүрэг байх ёсгүй тухай Үндсэн хуулийн цэц дээр ямар нэгэн мэтгэлцээн өрнөөгүй, гомдол гаргасан иргэн нь энэ заалт нь байх ёсгүй ээ. Үндсэн хууль зөрчсөн гэж хандаагүй. Цэцийн шийдвэр нь ер нь энэ заалтууд энийг арай жоохон өргөтгөөд л гээд байгаа байхгүй юу. 3 үндэслэл нь бол арай жоохон бага байна. Илүү жоохон өргөтгө гэдэг ийм дүгнэлт гарчхаад байгаа юм. Тийм учраас бид нар тэр “г” заалтыг гэдгийг нь нэмчхэж байгаа юм. “г” заалтыг. Энэ дээр Цогт шүүгч нэмж хариулах уу. 5 номерын микрофон.

Ц.Цогт: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Цэцийн дүгнэлт болохоор ингэж гарсан юм. Зөвхөн тэр хэрэг дээрх анхан болон давж заалдах шатын шүүхийн хууль хэрэглээ зөрөх юм бол авах болчихоод байна. Тэгэхээр наадах чинь зөвхөн тэр хэргээрээ хязгаарлагдаад байна. Гэтэл энэ хэрэг дээр анхан, давж заалдах нь нэг хуулийг ижил хэрэглээд, тэгтэл тэр хэрэглээ нь ижил төстэй үйл баримт дээр тухайн хуулийн заалтыг өөр шүүх өөрөөр хэрэглэчихсэн байвал энэ хууль хэрэглээний зөрүүг арилгаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана гэдэг тэр чиг үүргээ Дээд шүүх хэрэгжүүлж чадахгүй байна. Тийм учраас одоогийн энэ заалтын дагуу

шүүхүүдийн хууль хэрэглээний зөрүүг арилгах гээд ороод ирэхээр, тэр хэргийн гомдол гаргаж байгаа хэрэг дээрх шүүхийн хууль хэрэглээ нь зөвхөн тэр хэрэг дээрх анхан, давж заалдах шатын шүүхээр тогтохгүй өөр бусад ижил төстэй хэргийг дээрх хэрэглээтэй хэрвээ зөрж байгаа бол гэж үзвэл Дээд шүүх тэрийг аваад тэгээд энэ хуулийн зүйл заалтын хэрэглээг нэг мөр болгох тийм агуулгаар өргөжиж байгаа гэж ингэж үзэж байгаа.

Б.Энхбаяр: Мөнх-Оргил гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа яах, “г”-г нэмээд 25.7.5-г-г нэмээд өөрөөр хэлбэл эрх зүйн шинэ ойлголт эсвэл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэснээр арай өргөтгөж байна тийм үү. Тэрийг бол ойлгож байгаа юм. Гэхдээ анхан болон давж заалдах шатны гэдэг үгийг авч хаяснаар Цогт шүүгчийн саяын хэлж байгаа тэр тайлбар чинь бол үндэслэл муутай сонсогдоод байна л даа. Яагаад гэвэл шүүх гэдэг чинь тэртээ тэргүй л давж заалдах, анхан шат 2 л байгаа шүү дээ. Өөр юм байхгүй шүү дээ. Тэгээд анхан болон давж заалдах шатны гээд тодотгочихлоор зөвхөн тухайн хэрэг дээрээ яриад байгаа юм. Анхан болон давж заалдах гэдгийг нь авчихлаар бүхэлд нь шүүхийг яриад байгаа юм гэж. Тийм асуудал гарахгүй л дээ энэ чинь. Шүүхийн хуулийн хэрэглээ чинь тодорхой хэрэг дээр л гарна. Адилхан нөхцөл байдал дээр адилтган хуулийг өөрөөр хэрэглэчихсэн байх юм бол энийгээ засаад залруулаад л юу хийлгэсэн л байна.../минут дуусав/

Б.Энхбаяр: Мөнх-Оргил гишүүний микрофоныг нэмээд өгчих.

Ц.Мөнх-Оргил: Бүр одоо байгаа түдгэлзүүлэх гэж байгаа Цэцийн дүгнэлтээр 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс түдгэлзэж эхлэх энэ заалт дээр анхан болон давж заалдах шатны

шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах гэдэг дээр харин мушгивал юу гэж мушгиж болохоор байна вэ гэхээр зөвхөн анхан давж заалдах 2 хоорондоо зөрчилдөөд байгаа юм шиг, анхан шатын шүүхүүд хоорондоо 2 анхан шатын шүүх зөрчилдвөл хамаагүй юм шиг эсвэл 2 давж заалдах шатын шүүхийн шийдвэр зөрчилдвөл хамаагүй юм шиг тэгж ойлгогдож харин мушгивал мушгихаар байгаа байхгүй юу. Тэрийг Цэц тэгж явцууруулсан гэдэг чинь ингэж явцууруулаад байна гэж би цэц дүгнэсэн юм болов уу гэсэн чинь үгүй юм байна. Тэгэхээр энийгээ тодотгох юм биш үү. Эсвэл тайлбар хийх юм уу. Энэ дээр. Ямар “г”-ээс өөр тодотгох юм байхгүй юу. Тэрийг л манай ажлын хэсгээс л би асуугаад байгаа юм л даа.

Б.Энхбаяр: Энэ нөгөө Цэцийн өөрийнх нь шийдвэрээс болоод л бид ийм байдалд орчихоод байгаа шүү дээ ер нь. Цэцийн шийдвэрээ их ойлгомжтой үндэслэлтэй. Жишээлбэл Мөнх-Оргил гишүүний асууж байгаа 25.7.5.а заалтын “а” заалт Үндсэн хуулийн энэ заалттай яагаад нийцээгүй гээд Цэцийн шийдвэрт байсан бол бид тэрийг ойлгоод нэг хувилбар гаргах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр Цэц маань өөрөө “а” заалтад яагаад, ямар учраас, юу нь яг болохоо больчихсон гэдэг дээр 1 дүгээрт маргаан яригдаагүй байхгүй юу. Би итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон. Цэц дээр ийм маргаан өрнөөгүй. Улсын Их Хурал энэ асуудал дээр ямар нэгэн ийм маргаан өрнүүлээгүй. Гаргаж байгаа иргэд нь “а” заалтынх нь энэ нь ийм учраас буруу гэж ерөөсөө мэтгэлцээн, гомдол гаргаагүй байхгүй юу. Тэгэнгүүт Цэц шийдвэртээ болохоор яагаад ийм зөрчсөн, нийцээгүй гэдэг юм ерөөсөө хөндөөгүй мөртөө энэ “а” заалт нь нийцээгүй байна гээд л биччихэж байгаа юм.

Тэгэхээр бид нөгөө нэг ийм тааж уншаад байна шүү дээ. Тэгээд ингээд ер нь тэр нэг тарьсан баасан дээр нь дагаж Их Хурал халтираад баймааргүй байгаа

байхгүй юу. Юу тааж ингэж халтираад байх ёстой юм. Тэгэхээр зарчмын хувьд одоо энэ бодлого, үзэл санаа бол зөв байсан гэдэг зүйлээ Улсын Их Хурал хамгаалж мэтгэсэн. Гомдол гаргаж байгаа тал нь энэ хууль хэрэглээний зөрүүг арилгах ёсгүй ээ. Дээд шүүх ингэж ерөөсөө тийм гомдол гаргаагүй байхгүй юу. Тэгэхэд Цэц ингээд хүний гомдол гаргаагүй асуудал дээр Улсын Их Хурал энэ асуудал дээр тайлбар өгөөгүй асуудал дээр ийм шийдвэр гаргаж, тэгэхдээ бүр зөрчсөн гэж хэлэхгүй тэгсэн мөртөө. Тэгсэн мөртөө хууль тогтоогч энийгээ боловсронгуй болго гээд ийм юу нь мэдэгдэхгүй шийдвэр гаргаад байгаагаас л бид болоод байгаа байхгүй юу. Тийм учраас сая ажлын хэсэг дээр ярьж байгаад анхан болон давж заалдах гээд нэг үгийг нь аваад янзалчихъя л гэж байгаа юм. Цэцдээ бас нэг талаасаа хүндэтгэлтэй хандаад байгаа ухаантай шүү дээ. Ер нь бол бас дөргүй бух шиг зүтгээд байхгүй. Аль аль нь. Цогт шүүгч нэмж хариулах уу. 5 номерын микрофон.

Ц.Цогт: Мөнх-Оргил сайдын түрүүний тодруулж асуухдаа хэлдэг яг тэр агуулгаар Цэц, тэгээд Цэцэд мэдээлэл гаргасан иргэд ойлгож шийдвэр гарсан юм билээ. Уг нь бол хэдийгээр хуульд үгээ үгчлээ тайлбарлавал анхан, давж заалдах шатын шүүх тэр хэрэг дээр гэж ойлгогдохоор байгааг Дээд шүүх бол энэ заалтыг тайлбарлаж хэрэглэхдээ бол зөвхөн тэр хэргээр хязгаарлалгүйгээр авч шийдэж байсан. Зөрүүтэй хэрэглээ байгаа тохиолдолд. Тэгэхээр одоо ингэж залруулагдсан томъёоллоор бол яг таны хэлж байгаа шиг нэг түвшинд буюу анхан шатын шүүхүүд хуулийг өөрөөр зөрүүтэй хэрэглэсэн эсвэл анхан, давж заалдах шатын шүүх 2 өөр давж заалдах шатын шүүх, нийслэл дэх эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүх нэг эрүүгийн зүйл заалтыг нэг тайлбарлаж хэрэглээд Хөвсгөл дэх Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүх өөрөөр тайлбарлаж хэрэглээд байвал аль нэг

хэргийнх нь гомдлын дагуу аваад, энэ зөрүүг арилгах боломж нь үүсчээж байгаа юм. Харьцангуй ер нь.../минут дуусав/

Б.Энхбаяр: Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Баярлалаа. Үгүй ээ яах вэ, тааж Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг уншаад л, тааж бид нар хууль боловсруулаад л, тааж асуулт асуугаад л энэ чинь нөгөө Татаа Тунгаа юм уу юу юм. Энэ чинь арай дэндэж байна шүү дээ. Тэгээд би тэр ажлын хэсэгт нь орж ажилласан, ажилласан гэж дээ. Өчигдөр тэр ажлын хэсэг нь хуралдсан ёстой гайхамшигтай юм болж байна лээ л дээ. Би тийм ажлын хэсэг энэ олон жил парламентад суулаа. Ёстой хараагүй. Тэгсэн юу билээ нөгөө гар утсаараа яагаад л, би хөдөө явж байна гээд л нөгөө ажлын хэсгийн дэд хэсэгт нь байгаа нэг шүүгч нь тэгээд л нэг иймэрхүү маягтай л болдог юм байна лээ. Тэгэхээр ийм хууль байхаас ч яах вэ. Дараагийн ажлын хэсэг чинь бас болохгүй байна. Энэ чинь цөөнхийн төлөөлөл алга байна. Иймэрхүү юм хийхээр чинь ийм болно. Үндсэн хуулийн цэцэд л ингээд байгаа юм биш үү? Үгүй ээ наад шүүх чинь болохоо байчихсан байна. Тэр хараат, бие даасан Үндсэн хуулийн заасан тэр юмаа хэрэгжүүлж чадахаа байчихсан байна л гэдгийг хэлээд энэ дээр л анхаар гээд байгаа юм биш үү. Тэгсэн чинь энд байгаа нөхөд энэ олонх чинь хэн нэгэн хүнд тэр эрх мэдэл, шүүхийн эрх мэдлийг өгөх ёстой. Дээд шүүхэд нь атгуулах ёстой гэж уншаад байгаа юм биш үү. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг ханга л гээд байгаа юм биш үү. 3 газраа 3 өөр шийдвэр гаргана. Заримдаа 3 шатны шүүх гурвуулаа шийдчихсэн мөртөө тэрийг нь тэгээд хэн дуртай нь бас өөрчилдөг тийм л юм байдаг шүү дээ. Тэр Баярцогтын хэрэг байна. Зоригийн хэрэг байна гэсэн энэ юман дээр чинь л анхааруулаад байгаа юм уу гэж ойлгож байна. Тэр 25.8.10 дээр Давж заалдах шатын шүүхийн хэзээ, хаана, яаж

хуралдах журмыг нь тэгээд Улсын дээд шүүх нь Хяналтын шатын шүүхэд боловсруулж өгөх юм байна шүү дээ тээ. Тэр бүх эрхийг нь тэгж өгч байгаа юм байна. Энэ чинь улам л дордуулаад байна шүү дээ. Улам л дордуулаад байх шиг байх юм. Би ингэж ойлгоод байна. Тэгээд яагаад ингэж ингэж 3 шатын шүүх чинь шийдвэр гаргачхаад байхад яадаг юм. 3 газар 3 өөр шийдвэр гаргачхаад байхад яадаг юм. Энэ чинь хууль хэрэглээний нэгдмэл байдал гэж ерөөсөө байхгүй байгаа юм биш үү. Энд Улсын дээд шүүх гэж хэн тавьсан эзэндээ үйлчилдэг ийм л хэдэн нөхөд байгаа шүү дээ. Дохио зангаагаар хөдөлдөг. Үндсэн хуулийн цэц нь ч тийм байна. Дээд шүүх нь ч тийм байна. Тэгээд нөгөө балансаас баланст шилжиж очно гэдэг шиг, хэн эрх мэдэлтэй байна тэр рүү ингээд шилжээд оччихсон. Энэ их бүр завхралыг чинь эх үүсвэр болчихоод байна. Энд яах юм тэгээд 76 хулгайч хууль баталж байна л гээд байгаа. 76 хулгайч нь ч юу юм. Бас хулгайч нар байна л даа. Тэгээд тэр хуулийг нь би лав биш шүү. Гэхдээ энэ юм дээр нь дуугүй байгаад байгаа болохоор тэрийг нь хүлээн зөвшөөрч байгаа хүн шиг харагдаад байгаа байхгүй юу. Баянхонгорт өчнөөн шударга хүн байдаг юм шүү. Тэгвэл айн. ямар хүн байдаг юм? Өөрсдөө л нэрлэхгүй манай Баянхонгорт шударга бус хүн байхгүй. Ийм юмнуудад хариулт авмаар байх юм. Тэгээд Цогт шүүгч маань бас хөдөө гадаа яваад ядарч ирсэн байх ойлгож байна. Өчигдөр Энхбаяр даргын хувийн утсаараа л спикер дээр нь тавиад л яриад байх шиг байсан мөн үү, биш үү. Мөн ч юм уу, биш ч юм уу мэдэхгүй шүү дээ. Тэр утсаараа хэн нь ч яриад байгаа юм. Өчигдөр би асуугаад байсан. Өнөөдөр асуугаад байгаа энэ юманд нийлүүлээд нэг сайхан тайлбарлаад өгчхөөч. Цэц ямар юмаа тайлбарлах биш. Ажлын хэсгийн гишүүний хувьд таны ямар тэр Дээд шүүхийн гаргасан шийдвэрийг бол тэр Дээд шүүх дээрээ хууль хэрэглээний хувьд тайлбарладаг л юм байгаа биз. Энэ дээр энэ хууль юу нь болохгүй байна. Явал тэр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг

хангах юм бэ. Явал бие даасан шүүх байх юм бэ. Улсын Дээд шүүх чинь тэр мөрөөрөө л ажиллавал яадаг юм бэ. Битгий эрх баригчид.../минут дуусав/

Б.Энхбаяр: Ажлын хэсэг бол 5 гишүүний бүрэлдэхүүнтэй. 100 хувийн танхимаар ирцтэй хуралдсан өчигдөр. 100 хувийн ирцтэй хуралдсан шүү. Асуудлуудаа 100 хувийн саналаар дэмжиж оруулж ирсэн. Сая Ганбат гишүүний гишүүн нэг асуудал дээр цөөнх болсон байгаа. Ингээд нэг заалт дээр 80 хувийн ирцтэйгээр Байнгын хорооны хуралдаанд орж ирж байгаа гэдгийг хэлье. Мэдээж ажлын хэсгийн хүрээнд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах хүрээнд дэд ажлын хэсэг байгуулж ажилласан. Яагаад гэхээр шүүхийн процесстой холбоотой нарийн асуудлууд яригдаж байгаа учраас Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны байр суурь, мэдээллийг бид бас бүх юмыг мэддэг хүмүүс биш ээ, тодруулж асууж байх шаардлагатай гэдэг утгаар Улсын Дээд шүүхээс албан ёсоор томилогдсон яг энэ асуудал дээр нийт шүүгчдийн хуралдаанаасаа томилогдсон шүүгчээс бас хөдөө, орон нутагт томилолттой ажиллаж байсан ч гэсэн лавлаж гишүүдийн асуултад ажлын хэсгийн гишүүдийн асуултад хариулах бололцоогоор хангаж оролцуулсан байгаа шүү Ганбат гишүүн ээ. Та өөрөө асуулт асуусан. Таны асуултад хариулах бололцоогоор хангаж тийм видео дуудлага хийсэн асуудлыг л та яриад байх шиг байна. Тэгж ярих юм бол Улсын Их Хурал ковидын 2 жил цахимаар хуралдаж байсан шүү дээ. Гэрээсээ тэрийгээ мартчихсан. Түүхэнд байгаагүй би ийм цахимаар хуралдаж байсныг мэдэхгүй юм шигээр ийм саяхны юмыг бас ингэж ярьж болохгүй байх гэж бодож байна. Цогт шүүгч хариулах юм уу. 5 номерын микрофон хариулъя.

Ц.Цогт: Ганбат гишүүний асуултад холбогдох хэсэгт нь хариулъя. Яах вэ ер нь бол хууль тогтоох байгууллага, Дээд шүүхийн хоорондын

харилцаа бол хуулиар зохицуулагдсан байгаа асуудал. Ер нь бол. Тэгээд жишээлбэл Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 8.3-д заасны дагуу энэ шүүхийн өөрийнх нь зохион байгуулалт, тогтолцоо, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэж байгаа тохиолдолд энд Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэж санал гаргах ёстой ийм хуультай байгаад байгаа юм. Энэ хүрээнд Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гэдгээ танилцуулъя. Яг таны хэлдгээр тэр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдаад байна. Өөрөөр хэлбэл энд тэнд өөр өөрөөр шийдээд байна. Нэг хэрэг дээр шат шатын шүүхүүд өөр өөрөөрөө шийдээд байна гэдэг асуудлыг хуулиар зохицуулж, хуулт хэрэглээний нэгдмэл байдлыг хангахын тулд энэ Шүүхийн тухай хуулийн 25.7.5 гэсэн зохицуулалт орж ирсэн. Цэц бол юу гэсэн гэхээр 2 заалт нь бол хэтэрхий явцуу байна. Хяналтын журмаар гомдол гаргах эрхийг бус хангаж, тэгэх замаараа хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох бусад тэр боломжуудыг бол хязгаарласан байна гэсэн юм. Тэгэхээр нэгэнтээ Их Хурал хүлээгээд авчихсан учраас, авсан гэдэг нь Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч энийг өргөтгөө гэдэг зохицуулалт хуулийн төсөл боловсруулсан. Тэгээд энэ дээр бол Улсын Дээд шүүхээс ажлын хэсэгт нь орж ажиллаач гэж Хууль зүйн байнгын хорооноос санал ирсний дагуу бид ийм санал гаргасан байгаа. Тэгээд Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа, шүүн таслах ажиллагааны чанарт сайжруулах, зохион байгуулалтаа илүү боловсронгуй болгох, ингэх замаар нөгөө анхан шатын шүүхийн шийдвэрт гомдол гаргасан гомдлыг бүрэн дүүрэн барагдуулах, анхан шатын шүүхийн шийдвэр үйл ажиллагаанд процессын зөрчил гарсан уу, үгүй юу гэдгийг нягтлан, энэ процессыг нь бий болгох журмаар 25.8.10-ын заалт орж ирж байгаа. Түрүүн би тайлбарласан одоогоор бол ерөөсөө л 30

хоногийн дотор шийднэ. Тэгээд шүүх хуралдааных нь дэг өөр ямар нэгэн процессын зохицуулалтгүй байгаа юм. Тэгэхээр ийм журам гарвал илүү чанартай бэлдэж, давж заалдах шатын шүүх хуралдаанд оролцох, ингэснээрээ нөгөө гомдол гаргасан иргэний эрхийг бүрэн дүүрэн хангах чиглэлд хийж байгаа ийм өөрчлөлт байгаа. Яг энэ заалт бол.

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна. Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Горимын санал гаргая. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно гэж заасан байна. Тийм учраас анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд ээ, санал хураалт. 76,9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа оръё. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Саналтай гишүүд байна уу. Алга байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын саналаар санал гаргаж байна. Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 76,9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа оръё. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна саналтай гишүүн байна уу. Алга байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргаж байна. Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт 76,9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье ээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Саналтай гишүүн байна уу. Алга байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргаж байна. Горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 76.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Дууссан байна. Санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд би өрөө танилцуулчихъя. Ажлын хэсгийн ахлагчийн хувьд.

12.29 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.
“Ажлын хэсэг байгуулах тухай”
Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар Хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2023 оны 26 дугаар тогтоолоор даалгасны дагуу Монгол Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэг ба мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын онцлог, гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналттай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд 2023 онд багтаан өргөн мэдүүлэх үүргийг Хууль зүйн байнгын хороонд олгосон. Энэ хүрээнд холбогдох хуулийн төслийг боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлын хэсгийг байгуулахаар холбогдох тогтоолын

төслийг та бүхэнд тараасан. Холбогдох байгууллагуудаас ажлын дэд хэсэгт оруулахаар бас албан бичгийг хүргүүлсэн байгаа. Ажлын хэсгийн ахлагчаар миний бие, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Бат-Амгалан, Сүхбаатар, Б.Энх-Амгалан нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийг ажиллуулаад, Улсын Их Хурлын намрын чуулганаар өргөн барихад бэлтгэх ийм ажлын хэсэг байгуулж ажиллая. Энэ зун ажиллая гэж байгаа. Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Таны кноп ажиллахгүй байгаа юм уу. Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ер нь аливаа нэг хуулийг бас нэг нэлээн сайн боловсруулж бас ингээж гаргах нь зөв байх. Тэгээд энэ дээр чинь бас манай Улсын Их Хурал тэр тусмаа манай Хууль зүйн байнгын хороо бол хуулийн уураг тархи нь ч гэдэг юм уу, гал зуух нь ч гэдэг юм уу ийм Байнгын хороо. Тэгээд чанартай, зөв зүйтэй боловсруулж гаргах нь зүйтэй. Тэгээд энэ дээр бол ийм байна шүү дээ. Энэ ажлын хэсэг чинь цөөнхийн бүлгээс хүн алга байна. Цөөнхийн бүлгээс хүн алга байна. Тэгээд яагаад ингээд хууль муу боловсрогддог вэ, хууль муу гардаг вэ, амьдрал дээр үр дүн нөлөө багатай байдаг вэ гэдэг нь ойлгомжтой л байна л даа. Ингээд олонх маань ингээд гаргачхаад ийм хуулийг ингээд ажлын хэсэг нь ажиллаад, олонхоороо түрэмгийлж батлаад, ингээд амьдрал дээр гардаг. Тэр нь бол хөрсөн дээрээ буухгүй байна. Ийм шүүмжлэл бол ард иргэдээс их гарч байна шүү дээ. Энд та нар олонх болоод, янз бүрээр яриад байх нь яах вэ. Бас ард түмний элч болоод бас тодорхой нэгэн бүлэг байгуулагдаад, Ардчилсан нам ингээд ажиллаж байхад бас тэрнээс нэг хүн оруулахгүй ингээж хийнэ гэдэг чинь хууль чинь бас л ингээд

дутагдалтай болчхож байгаа юм. Тэгээд ажлын хэсэг чинь тэр Хөгжлийн банканд янз бүрээр холбогдсон хүмүүсээ оруулж болж байгаа юм уу, үгүй юм уу. Тийм хүмүүс байна уу, байхгүй юу. Тэрийгээ судалж барьсан юм байгаа биз дээ. 1 дүгээрт.

Бид нар энд түмний нүдэн дээр ил байгаа юмыг ярихгүй, тэгээд 1 хэвийн байгаа юм шиг ийм юм яриад л тэгээд элэг доог болоод л явах юм даа. Энэ дотор ч яах вэ миний араас янз бүрийн юм яриад л ингэх яах вэ. Хэчнээн мянга ярилаа ч гэсэн намайг шударга бус хүн болгож харуулж чадахгүй л юм чинь. Тэгээд бас тийм мянга яриад хэрэггүй. Тэгэхээр хэлж байгаа, ярьж байгаа зөв, зүйтэй юмыг тусгаад явах нь улс эх орны эрх ашигт нийцнэ. Явж явж дараа нь Ганбат гишүүний зөв л байдаг юм байна гээд л дуусдаг биз дээ та нар.

Б.Энхбаяр: Ажлын хэсэгт бол цөөнхөөс Алтанхуяг гишүүн орсон байгаа. Монгол Улсын бас Ерөнхий сайдаар ажиллаж байсан. Улсын бас нууцтай харьцаж ажиллаж байсан, бүх төрлийн нууцтай харьцаж ажиллаж байсан. Өөрөө яг энэ чиглэлийн бас Үндэсний аюулгүй байдлын талаарх мэдээлэл юмнуудтай бас танилцаж байсан ийм хүн учраас ажлын туршилага, байдлаар нь оруулаад цөөнхөөс оруулсан байгаа шүү Ганбат гишүүн ээ.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор гишүүд асуулт асууж дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Тогтоолын төслийг баталъя гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 53,8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

12.34 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Тэгвэл хууль зүйн дүгнэлтээ сонсчихъё.

Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн хууль зүйн дүгнэлтийг хэлэлцье.

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 4 гишүүн болон Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл, Ганбат нараас 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд дарга Үнэнбат танилцуулна. Үнэнбат даргын микрофон 6 номерын микрофон.

М.Үнэнбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ өдрийн мэндийг хүргэе.

Хууль зүйн дүгнэлт танилцуулъя. Хууль зүйн дүгнэлт 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдөр дугаар 2023/01 Улаанбаатар хот.

Хууль зүйн дүгнэлт гаргах үндэслэл.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нараас 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны хууль зүйн дүгнэлт гаргуулах тухай 2023 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн шийдвэр Улсын Их Хурлын Тамгын газарт 2023 оны 6 дугаар сарын 8-ны өдөр ирсэн. УИХ 10/5058 тоот албан бичгүүд тус тус үндэслэн энэхүү дүгнэлтийг гаргав.

Хууль зүйн дүгнэлт гаргахдаа Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4.23 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйл, 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалт, Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан хууль зүйн дүгнэлт гаргах журамд заасныг баримтлав.

Хууль зүйн дүгнэлтийн хүрээ, хязгаар. Хууль зүйн дүгнэлтэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар санал хурааж, дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зохицуулалттай зөрчилдсөн эсэх, хэрхэн нийцүүлэх. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор нэгтгэсэн төслийн дагаж мөрдөх хугацааг нийцүүлэх талаар Монгол Улсын Үндсэн хууль бусад хуультай нийцэж байгаа эсэх, хэрэгжих боломжийн талаар эрх зүйн дүн шинжилгээ хийлгэх тухай Төрийн байгуулалтын байнгын хорооноос өгсөн чиглэлийг үндэслэл болгов.

Нэг. Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь бусад хуультай нийцэж байгаа эсэх талаар.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийг хэлэлцэхэд нэгтгэсэн төсөлд хөндөгдсөн 2 дугаар зүйлийн 16 дахь заалт буюу 66.5, 4 дүгээр зүйл буюу 38.12, 42.1-ийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн байна. Санал хурааж дэмжигдсэн эдгээр саналын томъёолол Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдсөн эсэх талаар дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар ашиглахтай холбоотой зохицуулалтын талаар өргөн мэдүүлсэн. Нэгтгэсэн төсөлд 42.1 сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар дэлгэц ашиглаж болох ба зурагт самбар дэлгэц нь нэг хэсгээс 10-аас, аймгийн төв болон дүүргийн нэг хэсэгт 5, бусад хэсэгт 3-аас илүүгүй байна гэсэн гэж тусгасныг Байнгын хорооны анхны хэлэлцүүлгээр сонгуулийн зардлыг бууруулах зорилгоор тойрог тус бүрд нэр дэвшигчийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбартай байх зохицуулалтыг доор дурдсаар өөрчлөн найруулах санал гаргасан байна.

42.1. Тойрог тус бүрд нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбартай байна. Сум дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан журмын дагуу нэгдсэн самбарыг бэлтгэж, байрлуулах ажлыг зохион байгуулна. Нэгдсэн самбар дараах шаардлагыг хангасан байна.

42.1.1. энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн зурагт хуудсыг байрлуулах дарааллыг тогтооно.

42.1.2. сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй ашиглуулна.

42.1.3 Нэгдсэн самбарт байрлуулах нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны 4/1-ээс хэмжээтэй байна.

42.1.4 сонгогчийн тоонд үндэслэн сум 2 хүртэл, хороонд 3 хүртэл нэгдсэн самбар байрлуулна. Зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбарыг Сонгуулийн ерөнхийн хорооноос батлагдсан журмын дагуу сум, дүүргийн Засаг дарга бэлтгэж байрлуулах. Нэгдсэн самбар нь үнэ төлбөргүй байх зохицуулалт дэмжигдсэнтэй холбогдуулан хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2, 42.3, 42.4, 42.6, 42.7, 42.8 дахь хэсгүүдэд дурдсан зурагт самбар, дэлгэц гэсэн нэр, томъёог нийцүүлэх.

Зурагт самбарыг байршуулах, нам эвслээс нэр дэвшигчийг байршуулах дараалал зэргийг заасан бусад зохицуулалтыг нийцүүлж өөрчлөх шаардлагатай тул 42 дугаар зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулах нь зүйтэй байна.

Түүнчлэн тойргоос нэр дэвших сурталчилгааны нэгдсэн самбартай байх зохицуулалт дэмжигдсэн тул хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, 41.7, 41.11-д тус тус заасан ухуулах хуудас гэсэн нэр томъёог нийцүүлж жигдлэх, өөрчлөн найруулах эсэхийг шийдвэрлэх шаардлагатай байна.

2. Сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн тэмдэглэгээ хийх зохицуулалт дэмжигдсэн буюу 66.5 сонгогч саналаа тэмдэглэсэн хуудсаа санал тоолох төхөөрөмжид хийсний дараа тухайн сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол нь хуулийн 66.14 сонгогч саналаа өгснийг илэрхийлэх аливаа тэмдэг тэмдэглэгээ хийхийг хориглоно гэсэн зохицуулалттай зөрчилдөж байна. Иймд төсөлд хуулийн 66.14 дэх заалтыг хасах зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.

3. Нэгтгэсэн төсөл сонгуулийн сурталчилгааны хугацааг багасгаж 18 хоног болгож өөрчилсөнтэй холбоотойгоор хуулийн 38 дугаар зүйлийн 38.12 дахь хэсэгт төрийн аудитын дээд байгууллага нь энэ хуулийн 26.3.6, 26.4.6-д заасан тайлан сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнөөс эхлэн энэ хуульд заасны дагуу нам, эвсэл, бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлаа тайлангаа хүргүүлэх өдрийг дуустал өөрийн байгууллагын цахим хуудаст нээлттэйгээр байршуулна гэж заасантай зөрчилдөхөөр байна. Иймд 38.12 дахь хэсэгт заасан 22 хоногийг нийцүүлж 18 хоног болгох шаардлагатай байна.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбоотой нэгтгэсэн төслийн дагаж мөрдөх хугацааг нийцүүлэх талаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл Д.Ганбат нараас 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дагаж мөрдөх хугацааны талаар зохицуулалт тусгаагүй байна. 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуул хуулийн төсөлд дагаж мөрдөх хугацааг нийцүүлж, тодорхой болгох шаардлагатай байна. Эрх зүйн дүгнэлтийг танилцуулж дууслаа. Баярлалаа.

Б.Энхбаяр: Эрх зүйн дүгнэлтээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Ганбат: Ингээд сонгууль бол бас бид нар хэл амгүй хийчих ёстой ийм л ажил л даа. Тэгж байж энэ улс орны бүх юм чинь байх ёстой л гэж ингэж ойлгоод байгаа. Саяын энэ дүгнэлтүүд бол зөв зүйтэй. Хэд хэдэн хуулийн зүйл заалтууд хоорондоо ингээд нийцэхгүй болчихсон байна. Бэхэн тэмдэглэгээ бол ингээд ордгоороо орж ирэх үү.

2 дугаарт тэр нэр дэвшигчид маань нэг самбартай байна гээд ингэчихсэн байгаа. Нам маань бас өөрийгөө сурталчилна. Нам өөрөө бас жагсаалтаар ч юм уу, нэр дэвшигч дээрээ дамжуулж саналаа авна. Энэ юм хангагдаж чадах уу. Нам бол өөрийнхөө үнэт зүйл үзэл бодлоо ийм сурталчлах ийм боломжоор хангагдах ёстой гэж ойлгож байгаа. Ингээд ийм ийм зүйл заалтууд байгаа юу. Улсын Их Хурал 4 жил байна. Бүрэн эрхээ 4 жил

хэрэгжүүлнэ гэж байгаа. Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсан. Үндсэн хуульд өөрчлөлт оруулсантайгаа холбогдоод бас хооронд нь завсар үүсээд ямар нэгэн байдлаар хугацаанаас нь өмнө сонгууль явуулчих ийм боломжийг хэн нэгэнд олгочих вий. Тэр байтугай дайнтай байгаа Оросын Холбооны улс хугацаандаа сонгуулиа явуулж л байна. Газар хөдлөөд гамшиг болчихсон турк Ерөнхийлөгчийнхөө сонгуулийг бараг хугацаандаа шахуу ингээд л явуулж байна. Энэ юмнуудыг хааж өгсөн үү гэсэн ийм асуулт байна.

Нөгөө талаар бол энэ түрүүн ажлын хэсэг байгуулж байгаа талаар би бас дутуу ярьчихлаа. Энхбаяр дарга аа, аягүй л бол та иймэрхүү маягтай хандаад байх юм бол цөөнхийн бүлэг Хууль зүйн байнгын хорооны хуралд цаашдаа суухгүй болж мэднэ шүү. Тэрийг танд анхааруулчихъя. Алтанхуяг дарга бүтээн байгуулалт хийснийхээ төлөө өнөөдөр яллагдагчаар татагдсан байгаа байхгүй юу. Та 1937 оныг ханхлуулаад байна шүү. Хэлмэгдлийг. Алтанхуяг даргыг бас хэлмэгдүүлж байгаа. Яаж байгаа юм. Одоо яллагдагчаар татаж тэнд аваачаад хэлмэгдүүлж байгаа мөртөө, энд ажлын хэсэгт оруулчихсан гээд л ингээд доромжлоод сууж байдаг. Ийм байж болохгүй ээ. Эхлээд тэр хүнийгээ нэг тийш нь болгочоод, тэр хэлмэгдүүлэлтийг нь байхгүй болгочоод тэгээд ингэж харьцсан нь дээр байх аа. Тэгэхгүй бол 1937 оны үед нөгөө нэг авгайг нь авахын тулд хэлмэгдэлд явуулаад зүв зүгээр байсан хүнийг шоронд явуулчихаад ингэж байсан тал бий шүү дээ. Энэ байдал ямар нэгэн байдлаар энэ шинэ түүхэнд давтагдах тал энэ руугаа орох гээд байна шүү гэдгийг бас анхааруулъя. Ер нь яах вэ сонгуулийн хуультай холбогдоод ярихад бол бас энэ зүйлийг анхаарч ажиллах ёстой. Хууль зүйн байнгын хороо бол хуулийг хийдэлгүй, бас хөрсөн дээр нь буусан биелэгдэх боломжтой ингэж ажиллах ёстой шүү гэдгийг бас давхар анхааруулчихъя. Баярлалаа.

Б.Энхбаяр: Хүний гэм буруутай эсэхийг шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр шийдвэр гарахаас өмнө хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно гэсэн Үндсэн хуулийн зарчим үйлчилнэ. Энэ бол бүх хүнд үйлчилнэ. Монгол Улсын Их Хурлын гишүүн Алтанхуягийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шүүхийн шийдвэр гараагүй байгаа.

Харин та ингээд урьдчилж шүүхийн шийдвэр гараагүй байхад намынхаа журмын нөхрийг гэмт хэрэгтэн мэтээр ингэж цоллож ажлын хэсэгт оруулах буюу Их Хурлын гишүүнийх нь бүрэн эрх хүчинтэй байж байхад энэ бүрэн эрхийг нь харин хэн нэгэн эсхүл Байнгын хорооны дарга хязгаарлавал энэ харин хууль зөрчсөн асуудал болно. Эсрэгээрээ. Тийм учраас гишүүний бүрэн эрх нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэнбугайтай ч гэсэн Байнгын хорооны даргын хувьд хуульд заасан эрхийн хүрээнд нь харьцаж ажиллана гэдгийг танд бас хэлье. Үнэнбат Ганбат гишүүний асуултад хариулъя. 6 номерын микрофон.

М.Үнэнбат: Ганбат гишүүний асуултад хариулъя. Төрийн байгуулалтын байнгын хорооноос бол Сонгуулийн хуулийн зарим зохицуулалт, тэр тусмаа гишүүдээс болон ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй санал нь дэмжигдсэнтэй холбоотойгоор эрх зүйн дүгнэлт гаргуулах саналыг бол ирүүлсэн. Тэгээд чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу тухайн зарчмын зөрүүтэй саналууд нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Сонгуулийн хуультай холбоотой зөрчил үүсэж үү гэдэг дээр тэр бэхэн тэмдэглэгээний асуудал болон нэгдсэн самбарын асуудал мөн дагаж мөрдөх хугацааны асуудал гэсэн 3 зүйл дээр бол дүгнэлт хийж үзсэн. Тэгээд бэхэн тэмдэглэгээний тухайд бол сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа санал тоолох төхөөрөмжид хийсний дараа тухайн сонгогч саналаа өгснийг

илэрхийлэх бэхэн тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ гэсэн ийм заалт зарчмын зөрүүтэй санал дэмжигдчихсэн байгаа. Одоо байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Сонгуулийн хууль дээр бол ямар нэгэн тэмдэглэгээ хийхийг хориглоно гэсэн ийм зохицуулалт байгаа. Тэгэхээр энэ 2 хоорондоо зөрчил үүсэж байна гэж үзсэн учраас энийг бол засах нь зөв байна гэж үзсэн.

Түүнчлэн 42 дугаар зүйл дээр нэгдсэн 1 самбартай байна. Тэр самбарын хэмжээ дамжаа яаж байх ёстой вэ, хүмүүсийг яаж байрлуулах ёстой гэдгийг тэр тухайн журамд нь зохицуулаад ингээд явах ёстой санал мөн дэмжигдсэн. Тэгэхээр энэтэй холбогдуулаад 42 дугаар зүйлийг бүхэлд нь хооронд нь нийцүүлэх шаардлага бол байна гэж үзсэн. Түүнчлэн энэ 42 дугаар зүйлийн нэгдсэн 1 самбартай холбоотой, 41 дүгээр зүйл дээр мөн бас самбарын зохицуулалтууд байгаа учраас энийгээ бас саяын дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналтай бас нэгтгэх нь бол зөв юм гэж үзэж байгаа юм.

Тэгээд дээрээс нь 3 дахь зүйл нь саяын 2023 оны 5 сарын 31-ний өдөр баталсан Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор сонгуулийн зохицуулалт аль аль гишүүдийн өргөн барьсан хууль дээр бол дагаж мөрдөх журмын зохицуулалт бол байхгүй байгаа. Дэгийн хуулиар бол нэмэлт, өөрчлөлтийн төслийн тухай шинээр зүйл заалт, хэсэг, зүйлт нэмэхийг бол хориглодог учраас эрх зүйн дүгнэлт гаргаж байж дагаж мөрдөх хугацааны зохицуулалт хийх нь зөв юм гэсэн ийм дүгнэлт гарсан. Яг энэ хүрээнд бол бид эрх зүйн дүгнэлтийг танилцуулсан байна. Тодруулга алга байна дэгээрээ. Асуулт асууж үг хэлнэ гэсэн дэгтэй юм байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Хууль зүйн дүгнэлтийг дэмжиж Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 53,8 хувийн саналаар дэмжигдлээ.

Цогтбаатар гишүүн дэмжсэнээр сая тоног төхөө төхөөрөмж нь ажилласангүй гэж хэлсэн. Цогтбаатар гишүүнийг дэмжсэнээр аваарай.

Хууль зүйн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар танилцуулъя.

12.49 цаг.

Түрүүн хойшлуулсан асуудлыг хэлэлцье. “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн Бямбацогт сайд танилцуулна.

С.Бямбацогт: Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая .

Монгол Улс агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцод 1971 онд нэгдэн орсон. Олон улсын Иргэний нисэхийн байгууллагаас 2010 оны нисэхийн аюулгүй байдлын дипломат бага хурлаас иргэний нисэхийн эсрэг шинэ төрлийн хууль бус үйлдлүүд дэлхий даяар нэмэгдэж байгаатай холбогдуулан “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенцын нэмэлт протоколыг баталж, орхигдуулсан зарим шаардлагатай зохицуулалтуудыг нэмж тусгасан.

Агаарын хөлгийг хууль бусаар хүлээн авах үйлдлийг хориглох тухай Конвенцын нэмэлт протокол нь 2018 оны

1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд одоогоор нийт 35 улс гарын үсэг зурж, 21 улс соёрхон баталж, 21 улс нэгд орж, 1 улс хүлээн зөвшөөрч, 1 улс баталсан байна.

Энэхүү протоколд ашиглалтад байгаа агаарын хөлгийг хууль бусаар булаан авах, хяналт тогтоох үйлдэл, оролдлого, оролцооны хэлбэр, хүлээлгэх хариуцлага, гэмт үйлдлийн хамрах хүрээ, харьяалал, ялын байдал, төрийн байгууллагаас авах арга хэмжээ улс орнуудын хамтын ажиллагааны зохион байгуулалт зэргийг илүү нарийвчлан тодорхойлсон.

Монгол Улс нь “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенцын оролцогч улсын хувьд агаарын тээврийн салбарын хурдацтай өсөлттэй уялдуулан иргэний нисэхийн аюулгүй байдлын түвшин, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор энэхүү протоколыг соёрхон батлах шаардлага үүсээд байна.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенц нэмэлт протоколыг соёрхон баталснаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй. Хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27 дугаар бүлэгт өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа юм. Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Эрдэнэбат Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх, Мяндасмаа Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Мөнхтуяа Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Ганболд Иргэний нисэхийн ерөнхий газрын

Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албаны дарга гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Соёрхон батлах хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Баярлалаа. Их чухал конвенцод нэгдэж байгаа юм байна. Ингээд агаарын хөлгийн нислэгийн явцад бусад улс орнууд бас нэг ямар нэгэн асуудал бол тэр иргэдийг хамгаалах ийм хүмүүс дотор нь явдаг л даа. Тусгай байгууллагаас ч юм уу эсвэл тэр компаниасаа ч юм уу ийм юм байгаа юу, байхгүй юу манайд. Яах вэ конвенцод нь ингээд нэгдчихье. Тэр дотор нь байгаа хүмүүсийн аюулгүй нислэг энэ бүх юмнууд яаж хангагдаж байгаа вэ. Энэ тал дээр манай Үндэсний агаарын тээвэрлэгч билүү. Манай МИАТ чинь. Бид нарын үед тэгж нэрлэгдээд тэгээд юу нь хангагдсан байх. Тэгээд бас агаарын хөлгийг янз бүрээр дээрэмдсэн асуудалд орсон хүмүүс чинь ямар шийтгэл хүлээж байгаа вэ. Бид нар чинь цаазаар авах ялыг халчихсан л даа. Зарим хүмүүс бол цаазаар авчихъя л гээд байдаг юм байна лээ. Тэгээд хэн дуртайгаа цаазалчих вий дээ. Манай Алтанхуяг гишүүн бол Ардчилсан намаас сонгогдсон ийм гишүүн биш л дээ. Бие даагч. Ардчилсан намын бүлгийг төлөөлөхгүй шүү. Би харин тэр хуулийнх нь дагуу хуулийг нь Хууль зүйн байнгын хорооны даргад анхааруулчихъя. Хууль нь тийм юм байгаа юм. Битгий л цаазаар авчхаасай гэж бодож байна. Гэхдээ яг Үндсэн хуульдаа тэрийгээ бид нар хаагаагүй л дээ. Оруулаагүй. Энэ юмаа яаж шийдэж байна. Тэрийг нь нэг сонирхож байна.

Б.Энхбаяр: Хэн хариулах вэ. Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Агаарын хөлөгт бас тодорхой зөрчил, гэмт хэрэг үйлдэх

энэ асуудлуудыг зохицуулсан зохицуулалт одоогоор байхгүй байгаад байгаа юм. 2001 онд үндсэндээ нөгөө Америкийн Нэгдсэн Улсад болсон хэрэг явдлын дараа бол агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах, нислэгийн үйл ажиллагааг аюулгүй хангуулах тал дээр бол нэлээд өндөр шаардлага тавьж, өндөр арга хэмжээ авдаг болсон. Энэ бол үндсэндээ нисэхээс нь өмнө аюулгүй байдлын хяналт шалгалт маш сайжирсан. Ийм байдлаар л зохицуулж байгаа. Агаарын хөлөгт ямар нэгэн юу гэдэг юм хамгаалалтын ажилтан бол ажиллахгүй байгаа. Бид нар бас Америкийн Нэгдсэн Улсад open sky хэлэлцээр хийх гэж байгаа. Энэтэй холбогдуулаад ерөнхийдөө бас цаашидаа бас маршал нэртэй ийм бас ажилтан бас ажиллах шаардлагатай эсэхийг тэр үедээ ярихаар, ер нь бол оруулж ажиллахаар, зайлшгүй шаардлагатай тохиолдол оруулахаар ийм хуулийн зохицуулалт цаашидаа хийхээр төлөвлөж байгаа. Одоо бол энэ конвенцод нэгдэж орно. Нэгдэж орсны дараа бол нэгдэж орж байгаатай холбоотойгоор агаарын хөлгийн бүхээг дотор тэр хууль бусаар булаан авах, хяналт тогтоох тодорхой үйлдлүүд заналхийлсэн, албадсан, айлган сүрдүүлсэн ийм үйлдлүүд хийсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн дагуу бас хариуцлага хүлээлгэж болох ийм санкц оруулж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол ийм үйлдэл агаарын хөлгийн бүхээгт тодорхой заналхийлсэн, албадсан, айлган сүрдүүлсэн, нисэх үйл ажиллагаанд саад учруулсан ийм үйлдлүүд хийх юм бол 2 жилээс 12 жил хүртэл хугацаагаар ял эдлүүлэх, үүнд нь бас ийм үйлдэл хийсэн этгээдийг оргон зайлахад туслах юм бол 2 жилээс 5 жил хугацаагаар хорих ял шийтгэх иймэрхүү бас хуулийн заалтыг бас нэмж оруулъя гэсэн одоо хуулийн төслийг оруулж ирж байгаа гэдгийг хэлье. Нэмж хариулах уу манайхан болчихсон уу.

Б.Энхбаяр: Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Протоколд нэгдэж орохыг дэмжиж байгаа. л асуулт байна. Хуулийн төслийг дагалдуулж Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах төсөл санал болгож байгаа юм байна л даа. Тэгээд протокол чинь ерөөсөө бид нараас ийм л юм нэхээд байгаа шүү дээ. Эрүүгийн хуульдаа агаарын хөлгийг булаан авах гэмт хэргийг яг ийм бүрэлдэхүүнээр нь хуульчлаарай л гээд байгаа байхгүй юу. Тийм ээ. Энэ чинь протокол чинь ерөөсөө тийм юм байгаа шүү дээ. 3, 4 заалттай. Манай Эрүүгийн хуульд болохоор бүгдийг нь нийлүүлээд нөгөө конвенцынхоо заалтаас ёстой нөгөө өмнөх Цэцийн дүгнэлт шиг явцууруулаад ороод ирчихсэн юм шиг л харагдаад байх юм. Энэ дотор чинь юу гэдэг юм. Хүч хэрэглэх гэсэн үг байгаа. Манай хуульд болохоор хууль бусаар гэж үг хэрэглэх юм шиг байна. Хяналт тогтоосон гэж үг нэмж оруулсан байна. Тэгээд ашиглалтад байгаа агаарын хөлөг гэдгийг тайлбарлаагүй байгаа байхгүй юу. Энэ чинь гол нь тэр болчхоод байна шүү дээ. Яг агаарт байгаа гэж тооцогдох хөлөг нь хэд юм бэ гэхээр энэ конвенцоор чинь жишээ нь нислэг дууссаны дараа 24 цагийн дараа ч гэсэн ашиглалтад байгаа гэж тооцогдохоор байгаа байхгүй юу. Гэх мэтийн техникийн зохицуулалтын юмнууд орж ирээд байна л даа. Тэгэхээр ингэвэл яадаг юм бэ Энхбаяр дарга аа, Бид нар нөгөө олон улсын гэрээ конвенцын хэрэгжилтийг Байнгын хороогоороо нэг үзсэн шүү дээ. Тэрүүгээр чинь яг л ийм юмнууд гарч ирээд байгаа байхгүй юу. Конвенцоороо бид нар аягүй өргөн, маш тодорхой үүргүүд хүлээхээд байгаа байхгүй юу. Нэгдэж ороод ингэнэ, ингэнэ гээд 5 юмыг бид нар жишээ нь гэмт хэрэг болгож зүйлчилнэ. Дээр нь завдалтыг ингэж зүйлчилнэ. Цаг хугацааны хувьд ингэж зүйлчилнэ гээд, хуульдаа оруулна гээд үүрэг хүлээчихдэг. Яг оруулахаа болохлоороо бүгдийг нь нийлүүлээд оруулчихдаг. Тэгэхлээр нөгөө конвенцын хяналт энэ тэрийг хянаж байгаа хүмүүс чинь үгүй ээ, үгүй бид нар

чинь ингээж багцаар нь оруул гэж хэлээгүй шүү дээ. Ингээж салга гэсэн шүү дээ. Нислэг үйлдэхээс өмнөх тэдэн цагийн хугацаанд ашиглалтад байгаа гээд тооцно. Нислэг дууссаны дараа тэдэн цагийн дараа байгаа гээд тооцно. Тэр хамтран оролцохыг ингээж тодорхойлно гээд л ингээд л аягүй олон юм байгаа байхгүй юу. Тэгэхээр конвенцдоо нэгдэж орох тогтоолоо баталчхаад, Эрүүгийн хуульд яг энэ асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаа жижигхэн ажлын хэсэг байгуулаад үзчихвэл яадаг юм бэ. Тэгээд янзлаад оруулах уу. Энэ хууль бас анхны хэлэлцүүлгээрээ, Эрүүгийн хууль бас анхны хэлэлцүүлгээрээ батлагдаж болохгүй шүү дээ. Соёрхон батлахаа л баталчихъя. Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө авч үлдээд, дараа нь баталчихвал яадаг юм бэ. Тэгэхгүй бол жишээ нь яг маш тодорхой жишээ ийм байгаа байхгүй юу. Хүчээр алга болох конвенцод манайх нэгдээд орчихсон. Тэгээд хүчээр алга болох гэмт хэргийг ингээж тодорхойлно. Ийм, ийм, ийм элементүүдийг гэмт хэргийн элемент болгож оруулна гээд конвенцоор үүрэг хүлээчихсэн. Тэгэнгүүтээ Эрүүгийн хуульд оруулахдаа тэрийг зүйлийг нь болохоор хүчээр алга болгох гэмт хэрэг гэж зүйл ангийг нь биччихээд, доторх элементүүд нь болохоор хүн хулгайлах гэмт хэргийн зүйл ангиуд бичиж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө конвенцын хэрэгжилтийг шалгаж байгаа хүмүүс чинь манай дээр та нар энэ инфостезиперинс гэдэг гэмт хэргийг зүйлчил гэж хэлээд байхад чинь та нар киднапин гэдэг гэмт хэрэг зүйлчилчихсэн байна шүү дээ. Наадхаа салгаач гээд манай Хууль зүйн яамныхан дээр асуудал тавиад л сууж байгаа байхгүй юу. Гэх мэтийн юм яг энэ дээр гарчхаж магадгүй учраас жоохон яривал яадаг юм бэ.

Б.Энхбаяр: Мөнх-Оргил гишүүний сая хөндөж байгаа энэхүү конвенцыг дагаж Эрүүгийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Хууль зүйн байнгын хороо анхны хэлэлцүүлгийг нь тусад нь

хийнэ. Бие дааж хийнэ. Шууд дагуулж автоматаар батлахгүй гэдгийг бас танд хэлье. Бусад асуудал дээр нэмж хариулах ажлын хэсгээс хүмүүс байгаа юу. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулна. Саналын томъёоллыг та бүхэнд уншиж сонсгоё.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 76,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан танилцуулъя.

13.01 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.
“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай” конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Хуулийн төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Бямбацогт танилцуулна. Бямбацогт сайдыг урьж байна.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая аа.

Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн улсын хувьд тус байгууллагын бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, гэрээ, конвенцод нэгдэх, аюулгүй ажиллагааны аудит, хамтын ажиллагааны төсөл хөтөлбөр, сургалтад хамрагдах, хурал, чуулганд оролцох зэргээр Олон улсын иргэний нисэхийн үйл хэрэгт идэвхтэй оролцож байгаа.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 2010 оны нисэхийн аюулгүй байдлын дипломат бага хурлаас иргэний нисэхийн эсрэг шинэ төрлийн аюул занал, хууль бус үйлдээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, илүү үр дүнтэй арга хэмжээ авахад чиглэсэн эрх зүйн хэм хэмжээг бүрдүүлэх зорилгоор Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцыг баталсан.

Тус конвенц нь 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 34 улс гарын үсэг зурж, 23 улс соёрхон баталж, 19 улс нэгдэн орсон.

Энэхүү конвенцод олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд дурдаагүй орхигдуулсан зохицуулалтууд түүнчлэн гэмт хэрэгт тооцох үйлдэл, ялын байдал, гэмт хэргийн оролцогчид, хэргийн харьяалал, гэмт этгээдийг шилжүүлэх, хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлыг нарийвчлан тусгасан бөгөөд Монгол Улсын 1972 онд нэгдэн орсон Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсэх хууль бус үйлдлийг хориглох тухай Монреалын конвенц түүний нэмэлт протоколоос давуу хүчин чадалтай юм.

Агаарын тээврийг либералчилж нислэгийн тоо чиглэлийг эрчимтэй нэмэгдүүлж байгаа энэ үед манай улс нь иргэний нисэхийн аюулгүй байдлын стандарт түвшинийг олон улсын

шинэчлэн сайжруулсаар байгаа стандарт шаардлагад нийцүүлэх, энэ төрлийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог сайжруулах зайлигүй шаардлага үүсээд байна.

Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцыг соёрхон баталснаар иргэний нисэхийн аюулгүй байдлын түвшин, эрх зүйн тогтолцоог сайжруулахад дэмжлэг болох бөгөөд улсын төсвөөс нэмэгдэл зардал шаардахгүй.

Энэхүү конвенцын 1 дүгээр зүйлд гэмт хэрэгт тооцох үйлдлүүдийг тодорхой заасан бол 3 дугаар зүйлд 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт хүнд ял оногдуулахаар тусгасан. Иймд хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27 дугаар бүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулахаар байгаа болно.

Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг Соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдож хуралдаанд түрүүн дурдсан ажлын хэсгийн гишүүд хэвээр байгаа юм байна. Ажлын хэсэг бол хэвээрээ байгаа юм байна. Соёрхон батлах хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Соёрхон батлах хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулна. Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдлээ тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 76,9 хувийн саналаар дэмжигдлээ.

Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан танилцуулна.

13.05 цаг.

Дараагийн асуудалдаа орёё. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дах хэлэлцүүлгийг явуулна.

Ажлын хэсэг ороорой. Түрүүн ажлын хэсгийн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулсан байгаа.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн Учрал сайд танилцуулна. Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд хэрэглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7,9 хувиар өсөж, гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 дугаар сарын байдлаар 3,8 тэрбум ам.долларт хүрч сайжраад байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлт гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр инфляц төдийлөн буурахгүй, иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого, амьжиргааг дэмжих зайлиггүй шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулж, Монгол Улсын Засгийн газраас иргэдийнхээ орлогын баталгаа, амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр Төвийн тодотголын төсөлд тусгалаа.

Тухайлбал:

1.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрт олгохын зэрэгцээ хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгох,

2.Тэтгэврийн зөрүүний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх,

3.Төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчилж, суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх,

4.Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын сүлжээг өргөтгөх зэгээр нийслэлийн түгжрэлийг бууруулах арга хэмжээг төсвийн хооронд зохицуулалт хийж, шийдвэрлэхээр төсвийн төсөл тодотгоод байна.

Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1,7 их наяд төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлага 1,8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт алдагдал 1,6 их наяд төгрөг буюу анх батлагдсан дотоодын нийт бүтээгдэхүүний 2,6

хувиас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөлөө.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Энхбаяр: Одоо Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат танилцуулна. Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг танилцуулна. 3 номерын микрофон.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд 781,9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34,5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371,4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37,2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589,5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2,6 хувьтай байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотгол тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсөв 158,3 тэрбум төгрөгөөр, Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн төсөв 0,4 тэрбум төгрөгөөр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсөв 3,9 тэрбум төгрөгөөр, Улсын ерөнхий прокурорын төсөв 4,3 тэрбум төгрөгөөр, Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсөв 0,6 тэрбум төгрөгөөр, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын Комиссын даргын төсөв 0,1 тэрбум төгрөгөөр, Үндсэн хуулийн цэцийн даргын төсөв 0,2 тэрбум төгрөгөөр нийт 167,8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тус төсвийн Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлын нийт төсөв өсөхөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын хөрөнгө оруулалтын зардлын улсын төсөвт Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүртгэлийн техник хэрэгслийн зардалд 18,5 тэрбум төгрөгийг тусгасан, урсгал зардлын төсөвт төрийн албан хаагчдын цалин хөлсний системийг шинэчлэн, цалин нэмэгдүүлэн тогтоосон ажил олгогчдоос төлөхөд шаардлагатай Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал болон бусад зардалд 130,6 тэрбум төгрөгийг нэмж төсөвлөсөн нь нөлөөлжээ.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Баярлалаа. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн

ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Хууль санаачлагч болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ингээд Монгол Улсын эдийн засаг 7,9 хувь өссөн юм байна. Он гараад тэгж ойлголоо. Энэ юутай холбоотойгоор өсөөд байгаа юм бол. Энэ тэгээд тогтвортой ийм өсөлт байж чадах уу. 2023 оноо дуустал тэр мөнгөний ханишийн уналтад оролгүйгээр хүмүүсийн цалин пүнлүү нэмэгдсэн нь амьдралд нь хэрэг болж чадах уу. Тухайлбал өнөөдөр үүргээ гүйцэтгэж байгаа эргүүлийн цагдаагийн цалин хэдээр нэмэгдсэн бэ. Анхан шатын шүүгчийн цалин хэдээр нэмэгдсэн бэ. Миний ойлгож байгаагаар бол инфляц бол 2 оронтой тоонд сүүлийн 2, 3 жил явлаа. Нам доор түвшинд барина. 1 оронтой тоонд инфляцыг байлгана гээд амлаад байсан. 2023 оны төсвийг тэгж баталсан. Одоо 2023 он дундаа ороод явж байна. Тэгж инфляц нь 1 оронтой тоонд ороод байгаа юм ерөөсөө алга байна. 2 оронтой тоон дээр л явж байна. Тэгэхээр энэ бүх нэмж байгаа юм чинь инфляцад идэгдээд, хүмүүсийн цалин орлого нэмэгдсэн ийм үр дүнтэй, амьдралд нь хэрэг болохоор ийм нэмэгдэл байж чадах уу гэдгийг асууя.

Нөгөө талаар үүнийг дагаад хувийн хэвшилүүд байгаа. Энэ бол ингээд татвар төлөгчдийн ч юм уу, уул уурхайгаас орж ирж байгаа орлого байгаа байх л даа. Хэр тогтвортой байх юм бэ тэр нь. Нөгөө талаар энэ хувийн хэвшилүүд маань хэрэв тийм эдийн засаг нь сайн байгаад байгаа юм бол татварыг

нь багасгаж болдоггүй л юм байх даа. Ямар юм бол.

Нийт ард иргэдийн бас хувьцаа эзэмшиж байгаа Эрдэнэс Тавантолгой гээд компани байгаа. Энийг дагаад бас иргэд чирэгдэнэ ээ. Энэ хүмүүст тэгээд уул уурхай нь ашигтай ажиллаад байгаа юм уу эсвэл тэр далд эдийн засгийг ил болгоод байгаа юм уу. Аль нь юм би тэрийг нь учрыг нь бас ойлгохгүй л байгаа. Аль аль нь ч юм уу эсвэл нэг тал нь илүү юм уу мэдэхгүй байна. Тэгээд энэ дээр хууль хяналтын байгууллагад ажилладаг манай цагдаа нарын, шүүгч нарын, прокуроруудын цалин пүнлүү бол олигтой өсөөгүй байна. Инфляцын түвшинтэй уялдуулаад ингээд харах юм бол ерөөсөө бүгд л 5,9, 0,6, 4,3 гээд л ингээд ийм байдалтай харагдаад байх юм. Энэ яагаад ийм байгаа юм бол. Нөгөө хуульд захирагдаад л, дугуй яваад л, ингээд л үүрэг гүйцэтгээд л тангараг өргөсөн албан хаагчид гээд яваад байдаг. Энэ хэд маань юм хэлдэггүй болохоор эдний цалинги олигтой нэмэхгүй байгаа юм уу. Яагаад байгаа юм. Бид нар чинь албан үүргээ гүйцэтгээд явахад чинь ар гэртээ санаа зовох ийм асуудалгүйгээр л цалингаас өөр л орлого байхгүй шүү дээ. Байхгүй гэж ойлгоод байна. Тухайлбал шүүгч нар бол цалингаас өөр орлого байхгүй. Эх үүсвэр байх ёсгүй. Ганц нэг багшилдаг шүүгч нар байдаг юм уу, үгүй юм уу. Мэдэхгүй байна. Цагдаа нар ч гэсэн. Хилийн цэргийнхэн ч гэсэн. Албан үүргээ гүйцэтгээд хил дээр байгаа хүн бол ямар юмны нэмэлт орлого олох юм. Тэр байтугай гэр бүл ажилгүй хажууд нь байж байгаа шүү дээ. Энэ цалин пүнлүү бол хүмүүст мэдэгдэхүйцээр ингээд нэмэгдсэн зүйл алга байна гэж би хараад байна. Ар талын юмыг харж байхад. Тэгээд.../минут дуусав/

Б.Энхбаяр: Хэн хариулах вэ. Хосбаяр Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хосбаяр. 5 номерын микрофонд. Хууль сахиулах байгууллагуудын цалин пүнлүү олигтой

нэмэгдэхгүй байна. Нэмэгдсэн юм уу, үгүй юм уу гэдэг асуулт асуугаад байна.

Л.Хосбаяр: Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хосбаяр. Хуучин 452 дугаар тогтоолоор цагдаагийн ахлагч бүрэлдэхүүн бол 952 мянган төгрөгийн үндсэн цалин авч байсан бол, энэ нэмэгдлээр 1 сая 200 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл авахаар тооцогдсон байгаа. Үндсэн цалин нь. Цолны нэмэгдэл, төрийн тусгай албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдлүүд нь ороод 1 сая 800 орчим мянга ахлагч бүрэлдэхүүн авна.

Б.Энхбаяр: Их олон асуулт асуусан шүү дээ Ганбат гишүүн. Ганбат дарга Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. 1 номерын микрофон.

Ж.Ганбат: Ганбат гишүүний асуултад бид нар эхний 1 дүгээр улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 7,9 хувьтай гарсан. Энэ дотор нь уул уурхайн олборлолт, уул уурхайн салбарын өсөлт 5,3 хувьтай, үйлчилгээний салбар 3,8 хувийн ийм бол өсөлттэй гарсан байгаа. Мөн эхний 5 сарын байдлаар нүүрсний экспорт 24,4 сая тонн нүүрс бид экспортолчихсон байгаа. Тэгэхээр эхний 5 сардаа 4 сая гээд өнөөдрийн байдлаар аваад үзэхлээр 25 сая тонн нүүрс экспортод гаргаж Монгол Улс борлуулсан байгаа. Тэгэхээр үүнийгээ бүтэн жилдээ бид эхний 5 сардаа 24 гаран, өнөөдрийн байдлаар 25 сая тонн нүүрс экспортолчихсон юм чинь бүтэн жилдээ бол 50 сая тонн нүүрс экспортолохыг бол ингэж зорьсон. Тэгээд үүнтэй холбогдуулан нийт экспортоо нэмэгдүүлсэн байгаа. Бид энэ онд бол бид энэ оны төсөв батлахдаа 11,1 тэрбум ам.долларын экспорт хийнэ гэснийг бид 12,8 тэрбум ам.долларын экспорт хийнэ гэж нэмэгдүүлсэн байгаа. Импортыг мөн бас 300 орчим сая ам.доллароор нэмэгдүүлсэн байгаа. Тэгээд гол нөлөөлөл ерөөсөө л нүүрсний экспорт дээр л гол бид нарын орлогын нөлөөлөл, нийтдээ

1,7 их наядаар төсвийн орлого нэмэгдэж байгаа юм. 1 их наяд орчим нь бол нүүрсний экспортоос нэмэгдэж орохоор бол ингэж бол тооцсон байгаа.

Үнийн хувьд бол яах вэ нүүрсний үнэ бууралттай байгаа хэдий ч бид энэ оны төсөвт бол нүүрсний экспортын үнийг бол эхэлж батлахдаа 144 ам.доллароор тооцсон байгаа. Энэ ондоо өнөөдрийн байдлаар нүүрсний үнэ бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зах зээл дээр 140 орчим ам.долларын үнэд бол хэлбэлзэж байна. Буураад. Энэ нь дээшийгээ бид. Энэ бол нөгөө НӨАТ хассан үнэ нь. НӨАТ-ыг нь нэмэх юм бол 150 гаруй 160 орчим ам.доллар дээр яг урд талд бол сайн чанарын коксожсон нүүрсний үнэ бол байгаа. 6 сарын сүүлээс эхлээд буцаад нүүрсний үнэ тогтворжиж, нэмэгдэх ийм хандлагатай байгаа учраас бид бол экспортоо нүүрсний экспортоо ялангуяа нэмэгдүүлж чадсан. Тэгээд энэ оны яг төсвийн тодотголоор нэмэгдэж байгаа 1,7, 1,8 их наядын орлого бол орох бүрэн бололцоотой. Ингэж бол тооцсон байгаа.

Тэр цалингийн асуудал руу уг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулбал илүү тодорхой л хариулна даа.

Б.Энхбаяр: 6 Номерын микрофон Зулхар дэд сайд.

С.Зулхар: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ганбат гишүүний асуултад хариулъя. Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх бодлогыг амьжиргааны түвшин иргэдийн болон жишээ нь албан хаагчдын тэрнээс гадна инфляцын нөхцөл байдалтай уялдуулсан байдлаар бол тооцсон байгаа. Та тухайлсан байгууллагын төрийн тусгай албан хаагч, түүн дотроо цагдаагийн албан хаагчдын цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуулт асууж байна. Төрийн албан хаагч тэр дотроо жишээ нь төрийн тусгай албан хаагчдаас цагдаагийн болон

дотоодын цэргийн албан хаагчдын цалинг 2022 оны Засгийн газрын 452 дугаар тогтоолоор бол нэмэгдүүлсэн байгаа юм. Энэ бол 30 орчим хувиар нэмэгдсэн юм. Өөрөөр хэлбэл одоо бол цалин нэмэгдсэн байгаа нөхцөл. Саяны бидний төсвийн тодотголоор оруулж байгаа энэ саналаар бол цагдаагийн болон дотоодын цэргийн албан хаагчдын цалинг дунджаар бол 7 хувиар нэмэхээр бас ингэж оруулсан байгаа. Энэ бол инфляцын түвшин, амьжиргааны түвшинтэй бол уялдсан байдлаар нэмэгдэж байна гэж ойлгоно. Бусад нэмэгдлүүд нь ороод. Нөгөөтээгүүр бол үүнийг бид бас дундаж цалинтай бас уялдуулсан байдлаар харьцуулж үздэг. Дундаж цалин 1 сая 700 байгаа. Ингээд үзэх юм бол дундаж цалингаас их доогуур байгаа төрийн албан хаагчдын цалин бол энэ дундаж цалин руу дөхөж очихоор байна гэж бас тооцоолол хийж оруулж ирсэн.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Би тэр анхан шатын шүүгч нар ямар цалин, орлоготой байгаа талаар бас асуусан. Яагаад гэвэл цалингаас өөр орлогогүй ийм хүмүүс. 1 дүгээрт.

2 дугаарт сүүлийн үеийн дэлхий нийтийн байдалтай уялдаад манай хил, гаалийн асуудал бас нэлээн анхаарал татаж байгаа. Ялангуяа хойд хил. Тэнд бас хувийн зэвсэглэсэн отрядууд энэ тэр бий болчихсон шүү дээ. Тэгэхээр энэ хилийн цэрэг дээр бол онцгойлон анхаарах ёстой гэж би бодож байна. Тэд нар маань бас л гэр бүлтэйгээ ингээд нөгөө цалин орлого байхгүй шүү дээ. Гэр бүл нь ямар ажлын байр гэж байх юм биш. Тэр хүмүүсийн цалин орлого ямар болж байгаа вэ. Дэд ахлагч, ахлагч, гэрээт цэргийн албан хаагч гэж байна уу. Офицерууд нь ийм боломж бололцоо нь яг тэрнийх нь цалин, пүнлүү хэдээр нэмэгдсэн юм яг хэд байгаа юм тэрийг нь

хэлээд өгчих. Бас шүүгч нарыг хэлээд өгчхөөрэй.

Б.Энхбаяр: Нямбаатар сайд хариулъя. Нэг минут.

Х.Нямбаатар: Би Ганбат гишүүний асуултад хариулъя. Яах вэ Ганбат гишүүн ер нь бол цалинг хангалттай нэмэхгүй бол өнөөдрийн инфляци, хүмүүсийн худалдан авах чадвар, амьжиргааны түвшин, түүнтэйгээ л нийцэх ёстой гэж байна. Монгол Улсын Ерөнхий сайдын барьж байгаа зарчим бол тухайн жилийн инфляцын түвшинтэй цаашид төрийн албан хаагчийн цалинг уялдуулж нэмдэг энэ тогтолцоо руу шилжье гэдэг ийм чиглэл өгөөд, ажиллаж байгаа юм. Энэ удаагийн цалингийн нэмэгдэл бол ерөөсөө хөрөөний ир шиг байгаа цалингийн ялгамжтай байдлыг ижил түвшинд аваачъя гэж байгаа юм. Цагдаагийн ахлагчийн бүрэлдэхүүн, хилийн цэргийн ахлагчийн бүрэлдэхүүн, Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний цалинг саяын Хосбаярын хэлсэн цалингийн түвшинд яг жигдрүүлж аваачих. Өөрөөр хэлбэл ойролцоогоор 1 сая 200 мянган төгрөгөөс үндсэн цалин нь эхэлнэ. Үүн дээр хилийн цэрэг бол хилийн цэргийнхээ нэмэгдлийг, хууль сахиулагчийнхаа нэмэгдлийг, ажилласан жилийнхээ нэмэгдлийг, цолныхоо нэмэгдэлтэй ингээд авдаг байгаа. Энэ удаа Монгол Улсын Засгийн газраас барьж байгаа энэ төсвийн тодотголын.../минут дуусав/

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Минийх дээр нэмээд хариулчихгүй юу. Би бас тэр чигтээ асууна. Нямбаатар сайд энэ бүрэн эрхийн хугацаанд ер нь та салбарынхаа алба хаагчдын цалинг зөвхөн энэ нэмэгдэл биш, ноднин бас цагдаагийн алба хаагчдын цалинг тодорхой хэмжээнд нэмэгдүүлсэн. Ер нь хэд байж байгаад энэ бүрэн эрхийн хугацаанд ер нь хэдэн хувиар

нэмэгдүүлэв. Төрийн албан хаагчид бас энийг шүүж тунгаадаг байх. Аль Засгийн газрын үед, аль сайдын үед манай салбарын цалин хэдэн хувиар нэмэгдэв гэдгийг бас төрийн албан хаагч нар мэдэж байх ёстой. Ард иргэд бас мэдэж байх ёстой. Ерөөсөө цалин мөнгө нэмсэнгүй гээд гомдоллоод байдаг. Тэгвэл та бүхэн нэг өмнөх Засгийн газрын үед ер нь хэдэн хувиар нэмэгдүүлж байсан юм. Энэ Засгийн газар яаж нэмэгдүүлж байгаа юм. Би бол цагдаагийн албан хаагчдаа бас энэ хугацаанд 2 удаагийн нэмэгдэлтэй бас овоо нэмчхэв үү гэж харж байна. Гэхдээ өшөө ч нэмэх ёстой. Бололцоо боломж байдаг бол. Цагдаагийн албан хаагчдын ажил, чиг үүрэг бол өөр шүү. Бид бүхэн шиг ингээд оффис өрөөнд суучхаад ингээд ажилладаг хүмүүс биш. Бүх нийтээрээ улс орноороо баярлаж цэнгэж байхад бол цагдаагийн албан хаагчид хүйтэнд нь гадаа, халуунд нь гадаа зогсож л байдаг. Ар гэр үр хүүхдээсээ баярлуулж ч чаддаггүй ингээд зогсож байдаг. Тийм учраас тэр ажлын онцлог юмыг нь харгалзаж цалин мөнгийг нь нэмэгдүүлэх асуудал бол туйлын чухал. Бололцоо боломж байдаг бол өшөө ч нэмэгдүүлэх ёстой л гэж би хувьдаа хардаг. Тийм учраас цагдаагийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл ер нь бол энэ 4 жилийн хугацаанд хэдэн хувиар нэмэгдэв гэдгийг бас та бүхэн хэлж өгөөч.

2-т би бас энэ удаагийн тодотгол бол зөвхөн цалингийн нэмэгдэл гэж би харах юм. Гэтэл сая тэр танилцуулга дээр бас иргэний бүртгэлийн хөрөнгийн нэмэгдэл байна уу, үгүй юу. Энэ бусад байгууллагууд дээр бас хөрөнгө оруулалт юм нэмэгдээд байгаа юм биш биз дээ. Уг нь бол тодотголын нэмэгдэл цалингийн нэмэгдэл байх ёстой. Энэ дээр бас би буруу сонсчхов уу гэж ингэж асууя.

Манай Хууль зүйн байнгын хороонд харьяалагддаг 9 төсвийн ерөнхийлөн захирагчдын асуудал яригдаж байна. Дандаа төрийн тусгай албан хаагчид. Төрийн тусгай

байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргаа болоод төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин маань хэдээс хэд болж нэмэгдэж байгаа вэ. Хэд авч байгаад одоо хэд авах юм бэ гэдгийг тодруулж өгөөч. Тэгэхгүй бол бас төрийн тусгай албад нь болохоор цалин нь арай ахиу байда. Тэнд ажиллаж байгаа, арын албанд ажиллаж байгаа төрийн захиргаа болоод төрийн нийтлэг үйлчилгээнийхэн бас нэлээд бага цалин аваад байна гэдэг гомдлууд яригдаж байгаа. Тийм учраас энийг бас нэг тодруулж өгөөч гэж.

3-д Нямбаа сайд аа, энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа Багануурын 0427 дугаар нээлттэй, хаалттай анги байгаа. Энэ болохоор нөгөө алба хаагчдын орон нутгийн 30%-ийн нэмэгдэл ерөөсөө авдаггүй юм байна Ганбаа дарга аа. Яагаад гэхээр Багануурын гэдэг харьяаллаараа нийслэлийн дүүрэгт байдаг гээд. Тэгтэл яг газар зүйн байршилаараа Төв аймгийн Баяндэлгэр сумын газар нутаг дээр аймгийн төвөөсөө 130км алслагдчихсан бусад нөгөө хорих ангиудын алба хаагчтайгаа яг адилхан орон нутгийн нэмэгдлээ авах ёстой юм байна. Гэтэл өнөөдрийг болтол авч чадаагүй ингээд эрх ашиг нь бас хохироод явж байгаа юм байна. Энийг би бас Амарбаясгалан даргын нэр дээр албан тоот юмнуудыг нь өгсөн. Алба хаагчид нь бас тойргоос гарсан гишүүн гэдэг утгаараа бас миний нэр дээр албан тоот ирүүлсэн. Тэгэхээр энд ажиллаж байгаа алба хаагчдын ашиг сонирхол бас зөрчигдөөд байгаа юм байна шүү. Энэ дээр бас сайдын хувьд бас анхаарал хандуулж өгөөч ээ гэдгээ бас хэлье. Ийм 3 асуулт байна.

Б.Энхбаяр: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Сүүлийнх нь би асуултад шууд хариулчихъя. Тэр Багануур дүүргийн гэж харьяалагддаг яг нарийндаа газар нутаг, засаг захиргаа,

нутаг дэвсгэрийнхээ нэгжийн хувьд Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт оршиж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангийн тэр орон нутгийн нэмэгдлийг 2024 оны төсөв дээр бид нар суулгаад, орон нутгийнх нь нэмэгдлийг тооцуулж явах саналаа Сангийн яаманд хүргүүлсэн байгаа. Энийг манай яамныхан бас бичгээр Сандаг-Очир гишүүнд хариуг нь хүргүүлчихмээр байна. Өөрөөр хэлбэл цаашид Багануур дүүрэг дэх хорих анги гэж ярилгүйгээр нийтээрээ ярьж хэвших нь Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хаалттай хорих анги гэдэг энэ томъёоллоор явъя гэдгээ хэлье.

2 дахь зүйл нь ер нь манай хууль сахиулах салбар яг энэ удаагийн төсвийн тодотголоор орж байгаа энэ цалингийн нэмэгдэл дээр төдийлөн сайн нэмэгдэл очихгүй. Яагаад гэвэл бид нар бусад төрийн тусгай чиг үүрэгтэй байгууллагуудыг бодвол өмнө нь 2 удаа цалингийн нэмэгдэлд тооцуулчихсан юм. Одоо хийгдэж байгаа төсвийн тодотголоор хийгдэж байгаа цалингийн нэмэгдэл бол бусад тусгай чиг үүргийн байгууллагуудыг Хууль зүй, дотоод хэргийн салбарын төрийн тусгай байгууллагуудын цалингийн түвшинтэй ойртуулах, ижил болгох цалингийн нэмэгдэлд тооцогдож явж байгаа. Бид 2022 оны төгсгөл болон 2023 оны эхэнд тодорхой цалингийн нэмэгдлүүдийг төсвийн ерөнхийлөн захирагчид хууль, тогтоомжоор олгогдсон тэр эрх хэмжээнийхээ хүрээнд бид нар цалингийн сандаа багтаагаад цалингийн нэмэгдлүүдийг тооцоод явчихсан. Ер нь бол анх намайг ажил авч байхад шинээр ахлагчийн дамжаад төгссөн цууд томилогдож байгаа цагдаагийн дэд ахлагчийн хувьд 700 мянган төгрөгийн үндсэн цалингаас эхэлж байсан. Одоо энд төсвийн тодотгол яг батлагдсанаар үндсэн цалин 1 сая 250 мянган төгрөгөөс эхлээд тооцогдоно. Үүн дээр зарим тэр онцлогоос шалтгаалж 200 хүртэлх хувийн төрийн тусгай албан хаагчдын

төрийн тусгай чиг үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийн хувьд бол 200 хүртэлх хувийн нэмэгдэл цалингуудыг тооцох ийм боломжууд байгаа. Тухайлах юм бол цогцостой харьцсаны нэмэгдэл ч гэдэг юм уу, ажилласан жилийн нэмэгдэл, цолны нэмэгдэл, бусад нэмэгдлүүдийг ингээд тооцоод олон нэмэгдлүүд байдаг. Одоо Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас барьж байгаа нэг зарчим бол үндсэн цалинг нэг түвшинд аваачъя. Үүнээс гадна нэмэгдлүүдийг илүү их цөөлье. Маш тодорхой нэмэгдлүүд байя. Тухайлбал хилийн цэрэгт хилийн нэмэгдэл тооцъё. Цолны нэмэгдлийг тооцъё. Ажилласан жилийн нэмэгдлийг тооцъё. Салбар салбар өөрсдийнхөө тэр нэмэгдлүүдийг давуу байдлуудыг үүсгэж нэмэгдлүүдийг үүсгэж цаашид Монгол Улс дахь хөдөлмөрийн хөлсний ялгамжтай байдлуудыг илүү их арилгая гэдэг ийм агуулгаар төсвийн тодотголыг оруулж ирж байгаа юм.

Зүгээр би Ганбат гишүүний хэлж байгаа санааг дэмжиж байна. Ер нь цаашид Ерөнхий сайд ч гэсэн тэгээд байгаа юм. Ерөөсөө л инфляцынхаа түвшинтэй уялдуулъя гээд. Шүүгч нарын цалингийн тухайд бол энэ удаагийн би төсвийн тодотголоор нэмэгдэл орж ирээгүй гэж ойлгож байгаа юм. Энийг дагаад бид нар энэ 6 сардаа бид нар багтаж өргөн барих гээд байгаа Шүүх байгуулах хуультай уялдаж шүүхийн салбарын реформыг бид нар бас гүнзгийрүүлэх хүрээнд цалин, нийгмийн баталгаа, шүүхийн материаллаг баазыг бэхжүүлэх зэрэг олон цогц асуудлуудыг зэрэг хөндөхөөр бид нар хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд.../минут дуусав/

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би Ганбат даргаас ерөнхийдөө төрийн албан хаагчдын цалингийн энэ ялгаатай байдал, цалингийн сүлжээ нэг сүлжээнд ороод зөрүүтэй байдлууд тодорхой

хэмжээнд арилах юм байна гэж ингэж үзэж байна. Цаашидаа нэг сайдын гэдэг юм уу ялгаатай байдлаар салбарынхны цалинг нэмдэг байдал үүгээр зогсож байгаа юм байна гэж ингэж ойлгож байна. Зөв үү. Цаашидаа цалинг нэмэгдүүлэх асуудал яригдвал сууриар нь нийт төрийн тусгай, төрийн үйлчилгээ, төрийн захиргааны албан хаагчдын цалинг тэтгэвэр тэтгэмжтэй нь хамт нэмэгдүүлэх эсэх асуудлыг сууриар нь нийтэд нь ярьдаг болж байгаа юм байна гэж ингэж ойлгож байна. Зөв үү. Энэ удаагийн нэмэгдэл 2023 оны хагас жилд нэмэгдэж байна. Одоо 2024 он гарахаар ахиад 2024 онд инфляц ямар түвшинд байх юм. Хэрвээ 9 хувьтай байна гэж үзвэл 2024 онд ахиад 9 хувиар инфляц цалин тэтгэврийг.../минут дуусав/

Б.Энхбаяр: Ганбат дарга Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. 1 номерын микрофон.

Ж.Ганбат: Энэ төсвийн тодотгол бол ингээд төрийн албан хаагчдын цалингийн суурь хэмжээг нэмэгдүүлэх гэдэг дээр чиглэсэн л ерөөсөө яг төсвийн тодотгол хийгдэж байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр бид бол ерөнхийдөө цалингийн хэмжээнүүдийг ерөнхийдөө яг суурь хэмжээгээ нэмэгдүүлээд, нөгөө төрийн өндөр албан тушаалтнууд, Улсын Их Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, шүүгч, прокурорын бол цалин нэмэгдэхгүй байгаа. Энэтэй холбоотой бол ингээд өөрчлөлтүүдийг хийгдчихсэн. Ер нь бол цалин хөдөлбөл үүнээс цаашаа бид бол инфляцын түвшинтэй уялдуулаад жил болгон нэмэгдүүлэх ийм байдлаар цалингийн бодлогоо авч явъя гэдгээ л Засгийн газар дээр ярьж шийдвэрлэсэн. Тэгэхдээ яг таны хэлж байгаа, ойлгож байгаа зөв л дөө. Ирэх жил инфляцын түвшинтэй уялдуулаад бид цалингийн асуудлыг авч үзнэ. Өөр дахиж ингэж суурь цалин нэмэгдүүлэх гэдэг зүйн ярихгүй. Нэг удаа ингээд цэгцэлье гэдэг ийм л нэгдсэн ойлголтод хүрээд, энэ

тодотголыг хийж байгаа онцлог нь энэ л дээ. Би нэмэлт нэг түрүүнд та Сандаг-Очир гишүүн нэг зарим мэдээллүүд.../минут дуусав/

Б.Энхбаяр: Ганбат дарга, нэмэлт асуулт 1 минут. Нэмэлт асуултад хариулж байгаа хариулт 1 минут байгаа. Дэгээрээ. Тэрийгээ сайн барьж, цагаа харж асуулт асууж, хариулж байя. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт. Төсвийн тодотголын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Тэгэхээр санал хураалт байхгүй гэсэн үг байна шүү дээ. Зарчмын зөрүүтэй санал байхгүй учраас санал хураалт байхгүй ээ. Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир танилцуулна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дуусгасан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ. Баярлалаа гишүүдэд.

13.35 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ